

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2025 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2025 ОНЫ 07 ДУГААР САРЫН 01-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

**АЖ ҮЙЛДВЭРЖИЛТИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

2025 оны 07 дугаар сарын 01-ний өдөр, Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	0
Хуралдааны товч тэмдэглэл:	2-5
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	6-39

1.Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон “Монгол Улсын 2024 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2025.06.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд хүргүүлнэ/	6-24
2.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2025.06.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ/	24-34
3.Байнгын хорооны тогтоолын төсөл /Засгийн газарт чиглэл өгөх тухай/	34-36
4.Байнгын хорооны тогтоолын төсөл /Засгийн газарт чиглэл өгөх тухай/	36-39

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы
Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны 07 дугаар сарын
01-ний өдөр /Мягмар гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын гишүүн Д.Жаргалсайхан ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 23 гишүүнээс 12 гишүүн хүрэлцэн ирж, 52.2 хувийн ирцтэйгээр хуралдаан 11 цаг 16 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: С.Ганбаатар, Д.Энхтуяа;
Чөлөөтэй: Д.Батлут, Д.Бум-Очир, Ц.Даваасүрэн, П.Мөнхтулга,
Б.Пунсалмаа, Б.Тулга, М.Энхцэцэг;
Эмнэлгийн чөлөөтэй: С.Лүндэг.

Нэг. Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон “Монгол Улсын 2024 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2025.06.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд хүргүүлнэ/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Н.Учрал, Сангийн сайд Б.Жавхлан, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Жавхланбаатар, Санхүүгийн зохицуулах хорооны дарга Т.Жамбаажамц, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төрийн сангийн газрын дарга Б.Цогбадрах, Төрийн сангийн газрын Санхүүжилт, тайлан бүртгэлийн хэлтсийн дарга Н.Мөнхсүх, Төлбөр, тооцооны хэлтсийн дарга Н.Саруул, Санхүүжилт, тайлан бүртгэлийн хэлтсийн шинжээч Ч.Цацрал, ахлах мэргэжилтэн М.Алтанхорол, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга З.Тулга, мөн яамны Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга М.Дондогдорж, Санхүү, хөрөнгө оруулалтын газрын ерөнхий санхүүч Ц.Амгалан, Жижиг, дунд үйлдвэрийн газрын дарга Я.Эрдэнэсайхан, Зээлийн батлан даалтын сангийн захирал С.Цогтсайхан, Ашигт малтмалын газрын дарга Д.Оюунцэцэг, Эрдэнэс Монгол ХХК-ийн Нэгдсэн стратеги санхүүгийн удирдлагын газрын дарга Б.Батбаяр, Тагнуулын ерөнхий газрын Татвар хураалтын удирдлага, арга зүйн газрын дарга Р.Мягмаржав, Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн, Монгол Улсын Ерөнхий аудиторовын орлогч З.Цэдэнжав, Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд, Санхүү, нийцлийн аудитын газрын аудитын менежер Б.Долгорсүрэн, Д.Энхдалай, С.Нацагдорж, А.Цогбаяр, Э.Энхбаатар, В.Эрдэнэцогт, И.Эрдэнэцэцэг, Санхүү, нийцлийн аудитын газрын ахлах аудитор Ж.Бүжинханд, П.Батцэцэг, Б.Ариунжаргал, Ц.Энхжаргал, Б.Эрдэнэзул нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Инновац, цахим бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх

Б.Бат-Эрдэнэ, Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны ажлын албаны референт Г.Баярмаа, Хяналт шалгалтын газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн референт Ц.Лхагвагэрэл, Ч.Сарантуяа нар байлцав.

Тогтоолын төслийн талаарх танилцуулгыг Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Н.Учрал, Тогтоолын төсөлд хийсэн аудитын талаарх танилцуулгыг Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн нар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Батбаяр, Г.Лувсанжамц, Г.Очирбат, Д.Пүрэвдаваа нарын тавьсан асуултад Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Н.Учрал, Сангийн сайд Б.Жавхлан, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Жавхланбаатар, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга З.Тулга, Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн, Санхүүгийн зохицуулах хорооны дарга Т.Жамбаажамц, Татварын ерөнхий газрын Татвар хураалтын удирдлага, арга зүйн газрын дарга Р.Мягмаржав нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Д.Пүрэвдаваа үг хэлэв.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Очирбат Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 12 цаг 23 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2025.06.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн, Монгол Улсын Ерөнхий аудиторовн орлогч З.Цэдэнжав, Санхүүнийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, Гүйцэтгэлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд, аудитын менежер П.Чанцалдулам, Б.Долгорсүрэн, И.Эрдэнэцэцэг, Д.Энхдалай, С.Нацагдорж, А.Цогбаяр, В.Эрдэнэцогт, Ю.Энхтуяа, ахлах аудитор Б.Бүжинханд, Ж.Нямцэцэг, П.Батцэцэг, Б.Ариунжаргал, Ц.Энхжаргал, Б.Эрдэнэзул, Б.Долгоржав, У.Оюунхүү нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Инновац, цахим бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Бат-Эрдэнэ, Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны ажлын албаны референт Г.Баярмаа, Төсвийн хяналт шалгалтын газрын Төсвийн хяналт,

шинжилгээний хэлтсийн дарга Д.Эрдэнэсамбуу, мөн хэлтсийн референт Ц.Лхагвагэрэл, С.Төрмөнх, Ч.Сарантуяа нар байлцав.

Төсвийн төслийн танилцуулгыг Сангийн сайд Б.Жавхлан, Төсвийн төслийн талаарх аудитын дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн нар танилцуулав.

Хуралдаан даргалагч, Улсын Их Хурлын гишүүн Д.Жаргалсайхан Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийн талаарх танилцуулгыг Улсын Их Хурлын Тамгын газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсээс бэлтгэн ирүүлснийг танилцуулав.

Хуулийн төслүүдийн талаарх танилцуулга болон аудитын дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Очирбат, Х.Жангабыл нарын тавьсан асуултад Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Н.Учрал, Сангийн сайд Б.Жавхлан, Үндэсний аудитын газрын Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар хариулж, тайлбар хийв.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Очирбат Төсвийн байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 12 цаг 50 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Байнгын хорооны тогтоолын төсөл /Засгийн газарт чиглэл өгөх тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Инновац, цахим бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Бат-Эрдэнэ, Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны ажлын албаны референт Г.Баярмаа нар байлцав.

Байнгын хорооны 2024 оны 02 дугаар тогтоолоор байгуулагдсан “Таван толгой түлш” ХХК-ийн үйлдвэрлэл технологийн үйл ажиллагааны талаар шалган судлах, холбогдох санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий Хянан

шалгах ажлын хэсгийн санал дүгнэлтэд үндэслэн тус ажлын хэсгээс “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг танилцуулав.

Тогтоолын төслийн талаарх танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Ганзоригийн тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн гишүүн Г.Очирбат хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Г.Очирбат, Ж.Золжаргал нар үг хэлэв.

Д.Жаргалсайхан: “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн санал хураалт явуулья.

Татгалзсан 3
Бүгд 13
76.9 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 12 цаг 59 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв.Байнгын хорооны тогтоолын төсөл /Засгийн газарт чиглэл өгөх тухай/

Хуралдаанд Байнгын хороодын ажлын албаны Инновац, цахим бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Бат-Эрдэнэ, Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны ажлын албаны референт Г.Баярмаа нар байлцав.

Тогтоолын төслийн талаарх танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Ж.Золжаргал танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Жангабылын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн Ж.Золжаргал хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн С.Замира, П.Ганзориг нар үг хэлэв.

Д.Жаргалсайхан: “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн 10
Татгалзсан 3
Бүгд 13
76.9 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Улсын Их Хурлын гишүүн Д.Пүрэвдаваагийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 84.6 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Байнгын хорооны хуралдаанаар 4 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 54 минут үргэлжилж, 23 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 56.5 хувийн ирцтэйгээр 13 цаг 10 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
АЖ ҮЙЛДВЭРЖИЛТИЙН БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

С.ГАНБААТАР

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ГЭРЭЭТ АЖИЛТАН

Д.ЭНЭБИШ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 07 дугаар сарын 01-ний өдөр,
Мягмар гараг Төрийн ордон “Их эзэн Чингис хаан” танхимд 11 цаг 16 минут.

АЖ ҮЙЛДВЭРЖИЛТИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Д.Жаргалсайхан: Эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая аа. Байнгын хорооны хуралдаанд оролцож байгаа гишүүдийг танилцуулъя.

Далайн Батбаяр гишүүн байна, Ганзоригийн Лувсанжамц гишүүн, Даваахүүгийн Пүрэвдаваа, Пүрэвжавын Ганзориг гишүүн, Сонгобайн Замира гишүүн, Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан гишүүн, Болдын Уянга гишүүн, Жангабыл гишүүн, Золжаргал гишүүн, Очирбат гишүүн, Үүрийнтуяа гэсэн гишүүд ирсэн байна. Нийт ирц 52.2 хувьтайгаар эхэлж байна аа.

Байнгын хорооны хуралдаан нээснийг мэдэгдье ээ. Ингээд Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Нэгд нь Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгдсэн тайлан болон Монгол Улсын 2024 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл. Засгийн газрын 2025 оны 6 сарын 19-ний өдрийн өргөн мэдүүлсэн 2 дахь хэлэлцүүлэг. Санал дүгнэлтээ Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд хүргүүлнэ.

2 дахь асуудал. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, ЭМД-ын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд. Засгийн газар 2025 оны 6 дугаар сарын 25-ны өдөр өргөн мэдүүлсэн 2 дахь хэлэлцүүлэг. Санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ ээ.

3.Байнгын хорооны тогтоолын төсөл Засгийн газарт чиглэл өгөх тухай.

4.Байнгын хорооны тогтоолын төсөл мөн одоо Засгийн газарт чиглэл өгөх тухай ингээд 4 асуудлыг хэлэлцэхээр оруулж ирж байна аа.

Хэлэлцэх асуудалтай холбоотой саналтай гишүүд байна уу? За саналтай гишүүд байхгүй байна.

Нэг дэх асуудалдаа оръё.

Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгдсэн тайлан болон Монгол Улсын 2024 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн 2 дахь хэлэлцүүлгийг эхэлье ээ.

Ингээд ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя. Ингээд Монгол Улсын Ерөнхий аудитор Магнайсүрэн, Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн

сайд Учрал, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Жадамбаагийн Энхбаяр, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Жавхланбаатар, Сангийн яамны Төрийн сангийн газрын дарга Цогбадрах, Сангийн яамны Төрийн сангийн газрын Санхүүжилт, тайлан бүртгэлийн хэлтсийн дарга Мөнхсүх, Сангийн яамны Төрийн газрын төлбөр тооцооны хэлтсийн дарга Саруул, Сангийн яамны Төрийн сангийн газрын Санхүүжилт, тайлан бүртгэлийн хэлтсийн шинжээч Цацрал, Сангийн яамны Төрийн сангийн газрын санхүүжилт, тайлан бүртгэлийн хэлтсийн ахлах мэргэжилтэн Алтанхорол, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Батболд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Тулга, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Дондогдорж, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын ерөнхий санхүүч Амгалан, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Жижиг дунд үйлдвэрийн газрын дарга Эрдэнэсайхан, Зээлийн батлан даалтын сангийн захирал Цогтсайхан, Ашигт малтмал, газрын тосны газрын дарга Оюунцэцэг, Эрдэнэс Монгол ХХК Нэгдсэн стратеги санхүүгийн удирдлагын газрын дарга Батбаяр.

Үндэсний аудитын газраас: Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч Цэдэнжав, Санхүүгийн нийцлийн аудиторын газрын дарга, тэргүүлэх аудитор Наранчимэг, Гүйцэтгэл-нийцлийн аудиторын газрын дарга, тэргүүлэх аудитор Энхболд, Санхүү-нийцлийн аудиторын газрын аудиторын менежер Долгорсүрэн, Санхүү-нийцлийн аудитын газрын аудитын менежер Энхдалай, Санхүү-нийцлийн аудитын газрын аудитын менежер Нацагдорж, Санхүү-нийцлийн аудитын газрын аудитын менежер Цогбаяр, Санхүү-нийцлийн аудитын газрын аудитын менежер Энхбаатар, Санхүү-нийцлийн аудитын газрын аудитын менежер Эрдэнэцогт, Санхүү-нийцлийн аудитын газрын аудитын менежер Эрдэнэцэцэг, Санхүү-нийцлийн аудитын газрын ахлах аудитор Бүжинханд, Санхүү-нийцлийн аудитын газрын ахлах аудитор Батцэцэг, Санхүү-нийцлийн аудитын газрын ахлах аудитор Ариунжаргал гэсэн одоо аудиторууд ирсэн байна.

Ингээд Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгдсэн тайлан болон Монгол Улсын 2024 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх танилцуулгыг Хүнс, хөдөө аж ахуй. Учрал сайд уу? Энхбаяр сайд уу? Тийм Учрал сайд уу? тийм нэг дэх асуудал. За Тэргүүн Шадар сайд буюу Эдийн засаг, хөгжлийн сайд Учрал сайд танилцуулна аа.

Н.Учрал: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн төсвийн гүйцэтгэл Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгдсэн тайланг хуулийн хугацаанд нэгтгэн гаргаж, Төрийн аудитын төв байгууллагаар аудит хийлгэн, Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын чуулганы 6 дугаар сарын 23-ны өдрийн нэгдсэн хуралдаанаараа анхны хэлэлцүүлэг танилцуулсан билээ.

Монгол Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн 2024 онд 29 их наяд 670.8 тэрбум төгрөг, нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 30 их наяд 591.1 тэрбум төгрөг. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 2 их наяд 451 тэрбум төгрөгөөр сайжирч, 920.2 тэрбум төгрөгийн алдагдалтай гарсан ба сүүлийн 3 жил дараалан төсвийн алдагдлыг үе шаттайгаар бууруулж ажиллалаа.

Монгол Улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэл Засгийн газрын санхүүгийн нэгдсэн тайлан тус Байнгын хороонд харьяалагдах Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын багцын нийт 94 байгууллагын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг нэгтгэн гаргасан болно.

Тус Байнгын хорооны төсвийн ерөнхий ерөнхийлөн захирагчдын нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 744.8 тэрбум төгрөгийн гүйцэтгэл гарч, үүнээс урсгал зардалд 550.7 тэрбум төгрөг, хөрөнгийн зардалд 144.9 тэрбум төгрөгийг зарцуулсан байна аа. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд тус Байнгын хороонд харьяалагдах Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд 81 төсөл арга хэмжээнд 105.2 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгож, гүйцэтгэл 87.4 хувийн биелэлттэй байна аа.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Та бүхэн 2024 оны төсвийн гүйцэтгэлийн үр дүнгийн тоон үзүүлэлтүүд болон бусад холбогдох тайлан, танилцуулга, аудитын дүгнэлтүүдтэй танилцаж, Төсвийн тухай хуулийн дагуу Монгол Улсын 2024 оны төсвийн гүйцэтгэлийг батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэн, дэмжиж өгөхийг хүсье ээ. Баярлалаа.

Д.Жаргалсайхан: Учрал сайдад баярлалаа. Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгдсэн тайлан болон Монгол Улсын 2024 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөлд хийсэн аудиторын нэгдмэлтийн талаарх танилцуулгыг Монгол Улсын Ерөнхий аудитор Сандагийн Магнайсүрэн танилцуулна аа.

С.Магнайсүрэн: Улсын Их Хурлын Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Төрийн аудитын тухай болон Төсвийн тухай хуульд заасны дагуу төсвийн ерөнхийлөн захирагчдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Тус Байнгын хороонд харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагчдын санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын талаар тоймлон танилцуулъя.

1.Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 28 байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэснээс 19 байгууллагад дүгнэлт гаргаж, 9 байгууллагыг түүвэрт хамрууллаа. Аудитаар төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хязгаарлалттай, харьяа 5 байгууллагад өөрчлөлтгүй, 13 байгууллагад хязгаарлалттай, 1 байгууллагад сөрөг дүгнэлт өглөө.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 316 тэрбум төгрөгийн 198 зөрчил илэрснээс 0.2 тэрбум төгрөгийн зөрчилд 22 төлбөрийн акт, 254.5 тэрбум төгрөгийн зөрчлийг таслан зогсоох 89 албан шаардлага, 53.2 тэрбум төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 80 зөвлөмж, 2.3 тэрбум төгрөгийн зөрчилд хариуцлага тооцуулах 6 албан шаардлага хүргүүлж, хууль хяналтын байгууллагад 5.8 тэрбум төгрөгийн нэг асуудлыг шилжүүлэхээр шийдвэрлэсэн. Нягтлан бодох бүртгэл

тайлагналтай холбоотой нийт 79.6 тэрбум төгрөгийн 64 алдаа илэрснээс 78.3 тэрбум төгрөгийн 52 алдааг аудитын явцад залруулж, 1.3 тэрбум төгрөгийн алдааг залруулах 12 зөвлөмж өгөөд байна аа.

Өмнөх оны аудитаар өгсөн дараах зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байна. Үүнд Төсвийн ерөнхийлөн захирагчийн дэргэдэх дотоод аудитын алба, төрийн аудитын байгууллагаас хүргүүлсэн шийдвэрийн хэрэгжилтийг бүрэн хангуулах үр дүнтэй арга хэмжээ авч хэрэгжүүлэх.

2-т нь төсөв хөрөнгийн хөрөнгийг зохистой удирдаагүйгээс авлага өр төлбөр үүсгэсэн, тооцоо нийлж баталгаажаагүй, хугацаа хэтэрсэн болон олон жилийн насжилттай эрсдэлтэй авлагыг барагдуулах.

3-т нь төрийн өмчийн 51 хувиас дээш хувийн оролцоотой 3 компанийн санхүүгийн тайланг төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэх.

2-т нь Зам, тээврийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 36 байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэснээс 30 байгууллагад дүгнэлт гаргаж, 6 байгууллагыг түүвэрт хамрууллаа.

Аудитаар төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хязгаарлалттай, харьяа 16 байгууллагад өөрчлөлтгүй, 12 байгууллагад хязгаарлалттай, 2 байгууллагад сөрөг дүгнэлт өглөө. Санхүүгийн тайлангийн аудитаар 407.8 тэрбум төгрөгийн 271 зөрчил илэрснээс 0.1 тэрбум төгрөгийн зөрчилд 35 төлбөрийн акт тогтоож, 313.1 тэрбум төгрөгийн зөрчлийг таслан зогсоох 101 албан шаардлага хүргүүлж, 94.6 тэрбум төгрөгийн зөрчилд 134 зөвлөмж өгч, хариуцлага тооцуулах нэг албан шаардлага хүргүүлээд байна.

Нягтлан бодох бүртгэлд тайлагналтай холбоотой 416 тэрбум төгрөгийн 41 алдаа илэрснээс аудитын явцад 40 алдааг залруулж, нэг алдааг залруулах зөвлөмж өгсөн. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2.9 их наяд төгрөгийн төсөвт өртөгтэй тайлант онд 737.1 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй, 125 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталснаас 85 төсөл арга хэмжээг шинээр төлөвлөж хэрэгжүүлсэн байна. Тайлант онд 176.3 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 17 барилга байгууламж их засварын ажил байнгын ашиглалтад орсон ба нийт төсөл арга хэмжээний гүйцэтгэлийг хянаж 65.6 хувийн санхүүжилтийг олгожээ.

Өмнөх оны аудитаар дотоод хяналтыг сайжруулах алдаа зөрчлийг 20-иос доошгүй хувиар бууруулах албан шаардлагын хэрэгжилт хангалтгүй байна.

3.Хот байгуулалт барилга, орон сууцжуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд 10 байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэснээс 5 байгууллагад дүгнэлт гаргаж, 5 байгууллагыг түүвэрт хамрууллаа.

Аудитаар төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хязгаарлалттай, харьяа нэг байгууллагад өөрчлөлтгүй, 4 байгууллагад хязгаарлалттай дүгнэлт өглөө. Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 132.3 тэрбум төгрөгийн 51 зөрчил илэрснээс 1.2 тэрбум төгрөгийн зөрчилд 9 төлбөрийн акт, 2.8

тэрбум төгрөгийн зөрчлийг таслан зогсоох 29 албан шаардлага, 87.5 тэрбум төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 11 зөвлөмж, 40.8 тэрбум төгрөгийн зөрчилд хариуцлага тооцуулах 2 албан шаардлага тус тус хүргүүлсэн.

Нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой нийт 36.2 тэрбум төгрөгийн 18 алдаа илэрснээс аудитын явцад 17 алдааг залруулж, нэг алдааг залруулах зөвлөмж өгсөн.

4.Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 64 байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэснээс 52 байгууллагад дүгнэлт гаргаж, 12 байгууллагыг түүвэрт хамрууллаа. Аудитаар төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хязгаарлалттай, харьяа 38 байгууллагад өөрчлөлтгүй, 12 байгууллагад хязгаарлалттай, 2 байгууллагын санхүүгийн тайланд сөрөг дүгнэлт өглөө.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 253.1 тэрбум төгрөгийн 229 зөрчил илэрснээс 0.2 тэрбум төгрөгийн зөрчилд 38 төлбөрийн акт, 230.8 тэрбум төгрөгийн зөрчлийг таслан зогсоох 92 албан шаардлага, 22.1 тэрбум төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 98 зөвлөмж өгч, хариуцлага тооцуулах нэг албан шаардлага хүргүүллээ.

Нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой нийт 147.6 тэрбум төгрөгийн 68 алдаа илэрснээс аудитын явцад 64 алдааг залруулж, 4 алдааг залруулах зөвлөмж өгөөд байна аа. Өмнөх оны аудитаар өгсөн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд бүртгэгдээгүй 4.5 тэрбум төгрөгийн өр төлбөрийн үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулан, санхүүгийн тайланд бүртгэх зөвлөмжийн хэрэгжилт хангагдаагүй байна аа.

5.Эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд 33 тайлан нэгтгэснээс, 29 байгууллагын санхүүгийн тайланд дүгнэлт гаргаж, 4 байгууллагыг түүвэрт хамрууллаа. Аудитаар төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хязгаарлалттай, харьяа 25 байгууллагад өөрчлөлтгүй, 4 байгууллагад хязгаарлалттай дүгнэлт өглөө. Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 145.4 тэрбум төгрөгийн 209 зөрчил илэрснээс 0.2 тэрбум төгрөгийн зөрчилд 45 төлбөрийн акт тогтоож 74.5 тэрбум төгрөгийн зөрчлийг таслан зогсоох 88 албан шаардлага, 70.7 тэрбум төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 76 зөвлөмж өглөө. Нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой 123.5 тэрбум төгрөгийн 73 алдааг аудитын явцад залрууллаа.

Өмнөх оны аудитаар өгсөн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн 92.1 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 63 төсөл арга хэмжээг Улсын комиссын актаар хүлээн авсан боловч ашиглагч байгууллагуудад шилжүүлээгүй 36.3 тэрбум төгрөгийн хөрөнгийн бүртгэл, өмчлөлийн асуудлыг шийдвэрлүүлэх зөвлөмжийн хэрэгжилт хангагдаагүй байна аа.

Дээр дурдсан аудитын дүн дүгнэлтээс үндэслэн дараах асуудлууд анхаарлаа хандуулах шаардлагатай байна. Үүнд:

1 дүгээрт, төсвийн ерөнхийлөн захирагчдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудад хэрэгжүүлэх дотоод хяналтыг сайжруулах. Төрийн аудитын байгууллагаас хүргүүлсэн шийдвэрийн хэрэгжилтийг бүрэн хангуулах, хангуулахад чиглэсэн үр дүнтэй арга хэмжээ авч хэрэгжүүлэх.

2-т нь төсвийн ерөнхийлөн захирагчдын хэрэгжүүлсэн хөтөлбөр, хөтөлбөрийн үр дүн, чанар, тоо хэмжээг төсвийн гүйцэтгэлтэй уялдуулан хяналт шинжилгээ, үнэлгээ хийж баталгаажуулах.

3-т нь худалдан авах ажиллагааг хууль тогтоомжид нь нийцүүлэн зохион байгуулах.

4-т нь төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах. Төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулах хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулах.

5-д нь төсвийн хөрөнгө төсөв хөрөнгийг зохистой удирдаагүйгээс авлага, өр төлбөр үүсгэсэн, тооцоо нийлж баталгаажуулаагүй, хугацаа хэтэрсэн болон олон жилийн насжилттай, эзэн холбогдогчгүй болж найдваргүй болох эрсдэлтэй авлагыг барагдуулах.

6-д нь эрх бүхий байгууллагуудын шийдвэрээр төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүдээр нийгмийн шинж чанартай төсөл арга хэмжээг санхүүжүүлж, төсвийн нэгдсэн бодлогын зарчмыг зарчим алдагдуулж байгаа зөрчлийг таслан зогсоох.

7-д нь төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн засаглал, эрх зүйн орчныг олон улсын жишигт нийцүүлэх. Үйл ажиллагааны хараат бус, ил тод байдлыг хангаж ажиллах.

8-д нь хуулийн этгээдүүдийн зорилтот түвшний төлөвлөлт, гүйцэтгэлийг хянаж нэгтгэх, үр дүнг үнэлэх зохих арга хэмжээг тухай бүр авч хэрэгжүүлэх шаардлагатай байна аа.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Жаргалсайхан: Монгол Улсын Ерөнхий аудиторт баярлалаа. Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл Засгийн газрын санхүүгийн нэгдсэн тайлангийн талаарх Тэргүүн Шадар сайд болон аудитын танилцуулгатай холбогдуулан асуулт асуух гишүүд саналаа өгнө үү.

Ингээд эхний асуултыг Далайн Батбаяр гишүүн асууна аа.

Д.Батбаяр: Ажлын хэсгийнхэнд энэ өдрийн мэндийг хүргэе ээ. Шадар сайдаас асуух асуулт байна аа. Энэ Үндэсний аудитын газрын санал, дүгнэлтийн 3.3.30, 33-т байгаа гадаадын зээл гэрээ хэлэлцээрийн хүрээнд авч ашиглаагүй зээлийн хэмжээнд 39.4 тэрбум төгрөг төлж, өмнөх оноос 27 тэрбумаар нэмэгдсэн байна аа гэсэн ингэж орж ирсэн байна. Тэгэхээр энэ ямар зээлүүд нь, хаанахын ямар төсөл хөтөлбөрийн зээлүүд ашиглагдаагүй үлдсэн бэ? Ямар шалтгаанаар ашиглагдаагүй тэгээд хүү нь тооцогдоод явж байгаа вэ. Энэ ер нь 2025 ондоо ер нь ямар байдлаар шийдье гэж байгаа вэ гэдэг 1 дүгээр асуулт байна аа.

2 дугаарт нь ХААЯ-наас хэн байгаа билүү сайд байгаа тиймээ. Энхбаяр сайд. Энэ юу байна л даа. Нөгөө бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээн дээр нь малын архаг өвчнөөс, халдварт өвчнөөс эрүүлжүүлэх гээд нэлээн 4, 5 төрлөөр нь зардал гаргачихсан байна л даа. Малын гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, малын архаг халдварт өвчнийг эрүүлжүүлэх, тэгээд мал амьтан эрүүлжүүлэх, малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, малын гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, малын архаг халдварт өвчнөөс эрүүлжүүлэх 1, 2, 3, 4, 5, 6 ингээд нийтдээ 6 төрлийн зардал гаргаад ингээд явчихсан байгаад байх юм. Энийг ингэж ангилахын учир юу байдаг юм бол? Тэгээд энэний үр дүн нь ямархуу байсан юм бол? Гүйцэтгэл ер нь ямархуу байсан юм бол гэдэг 1 дүгээр асуулт байгаа юм.

2 дугаарт нь энэ хөнгөн үйлдвэрийн үндэсний хөтөлбөрүүд гээд 356 тэрбум төгрөг байх шиг байна тиймээ. 56 сая төгрөг байна. За энэний үнийн дүн энэ оронг нь тодруулчхаарай. Тэгээд ийм зардал хөнгөн үйлдвэрийн үндэсний хөтөлбөрүүдэд хэрэгжсэн юм байна аа. Тэгээд энэ хөтөлбөрийн хүрээнд ямар ямар арга хэмжээ авч хэрэгжүүлсэн юм бол? үр дүн юу байсан бэ гэсэн ийм асуултууд байна.

Д.Жаргалсайхан: Сангийн сайд хариулъя, микрофон өгөөрэй. Сангийн сайдын микрофон өгөөрэй. За 6-г. 6 дээр микрофон өгөөрэй.

С.Тулга: Сайн байна уу? Сангийн яамны Тулгаа. Гишүүний асуултад хариулъя. Энэ сая гишүүний ярьсан асуудал нь нөгөө нэг бид нар коммитмент фи гэж байдаг. Одоо гаднын талтай зээлийн том гэрээ байгуулчхаад тэгээд түүндээ яг ашиглагдаагүй үлдэгдлээсээ бид нар тодорхой хэмжээний төлбөр төлдөг. Яагаад гэвэл гаднын донор байгууллагууд маань тэр манай байгуулсан гэрээний хүрээнд тэр хөрөнгийг өөр этгээдэд зээлүүлэх боломжгүй яг энэ түгжигдэж байгаа энэ баталгаа үзүүлж байгаа одоо ийм коммитменти учраас ерөнхийдөө 0.5 хувь ашиглагдаагүй зээлийн үлдэгдлийн 0.5 хувийн шимтгэл төлдөг өө.

Тэгээд 2024 оны байдлаар бол 39.4 тэрбум төгрөгийн бид нар коммитментийг төлсөн. Энэ удаа ашиглагдаагүй зээлийн үлдэгдэл 12 их наядаас тооцогдож байгаа. Үүний 25.6 нь Энэтхэг дээр. Энэтхэгийн газрын тос боловсруулах үйлдвэр дээр бид нар коммитментийг төлөөд явж байгаа. Австри байна, Азийн дэд бүтцийн хөгжлийн банк, Азийн хөгжлийн банк, Герман, Дэлхийн банк, Европын сэргээн босголт хөгжлийн банк, Хятад гээд зэрэг энэ доноруудаас бид нар бол ерөнхийдөө коммитментийг төлөөд явж байгаа.

Д.Жаргалсайхан: Ингээд 2 дахь асуулт хэн хариулах вэ. Энхбаяр сайд уу?

Ж.Энхбаяр: Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамжтай холбоотойгоор энэ бол мал аж ахуйг хөгжүүлэх хөтөлбөрийн хүрээнд бид малын халдварт өвчин, 6 нэр төрлийн одоо халдварт өвчин байгаа. 6 нэр төрлийн вакцин худалдан авалт. Тэрийг одоо тарьж үйлчлэх асуудал байдаг. Малын гоц халдварт 4 өвчин байгаа. Малын архаг одоо бруцеллөз гээд нэг ийм өвчин байгаа. Ингээд өвчин болгоноороо ордог орц нь өөр, вакцин нь өөр, эм бэлдмэл нь өөр. Манай Мал эмнэлгийн ерөнхий газрын манай салбарын нэг онцлог бол энэ иргэдэд хүрч байгаа үйлчилгээ 100 хувь хувьчлагдсан байгаа. Мал эмнэлгийн тасгууд буюу мал хувийн мал эмнэлгүүд сум болгонд 2-3 байгаа. Эд нар Мал эмнэлгийн ерөнхий газартай хийсэн гэрээний дагуу тэр үйлчилгээг буюу тэр вакцинжуулах ажлыг хийгээд, баталгаажуулах ажлаа хийгээд, тэнд нь...

Д.Жаргалсайхан: Нэмэлт өгөөрэй.

Ж.Энхбаяр: Тэр үйл ажиллагаанд нь орон нутгийн хөдөө аж ахуйн газар мал эмнэлгийн харьяа газрууд хяналт тавиад ингээд явдаг. Тэрний үр дүнд. Үр дүн юу юм бэ гэж. Үр дүн ерөөсөө л экспорт. Сүүлийн 2023, 2024 оны гүйцэтгэлээр бид нийтдээ нэг 600 сая долларын мах олон улсын зах зээлд гаргаж чадлаа. Дэлхийн 30-аад орны мал эмнэлгийн байгууллагуудтай харилцан гэрээ протоколуудаа хийж, манай малын махыг импортлох зөвшөөрсөн. Бид чинь 90 оноос хойш ингээд мал махаа экспортод гаргах гээд нэлээн олон орлого хийсэн. Нэг 10, 20 сая доллароос хэтэрч үзээгүй. Сүүлийн 2 жил бол 600 хүртэл сая долларын мах гаргадаг болоод явж байна. Энэ нь өөрөө бид нарын энэ мал эмнэлгийн энэ халдварт өвчнөөс сэргийлэх бодлого амжилттай, вакцинжуулалт тогтвортой хийсний үр дүн. Энэ бол өөрөө нөгөө хүнсний хувьсгал. Их Хурлын 63 тогтоол...

Д.Жаргалсайхан: Болсон уу? За дахиад нэмэлт өгье.

Ж.Энхбаяр: Тавхан 5 минут ахиухан өгчих. Их Хурлаар батлагдсан Хүнсний хувьсгал 63 дугаар тэр тогтоолд орсон хөтөлбөрийн хүрээнд мал эмнэлгийг бодлогоор ингээд сайжруулж ирсний үр дүн одоо гарч байгаа. Энэ чинь 4, 5 жил тогтвортой явж байж ингээд экспорт нэмэгдэж байгаа, энийгээ дагаад малчдын орлого нэмэгдэж байгаа. Нөгөө талаас Монгол Улсын энэ хөгжлийн бодлогуудад бид нар малынхаа тоог цөөлөх бодлого барьж байгаа. Хонь, ямаа, адууг бол цөөлөх хэрэгтэй. Үхэр, тэмээгээ тоогоо өсгөө гэж ашиг шимт байдлаа нэмэгдүүлье гэсэн ийм бодлоготой. Учир юу вэ гэвэл бэлчээрийн даац жилдээ нэг 20-25 сая хонин толгойд шилжүүлснээр даац хэтрээд байгаа. Бэлчээрийн 70 гаруй хувь нь одоо нэлээн доройтолд ороод, нөхөн сэргээгдэхэд эрсдэл үүсээд байгаа нь хэт одоо малын хөлд талхлагдаж байгаа байдал.

Тэгэхээрээ Монгол Улсад бол ашиг шимт нэг 50-60 сая малтай ингээд тогтвортой байхад бол бэлчээрээ хамгаалаад, нүүдлийн мал аж ахуй одоо тогтвортой хөгжих бололцоотой. Ингээд хэтэрч байгаа тэр тоог бид нар экспортын бодлого...

Д.Жаргалсайхан: Бас дахиад дутуу байна аа гэж байна. Нэмж өгье.

Ж.Энхбаяр: Тэгэхээр үр дүн энэ экспортоор гарч байгаа. За нөгөө үйлдвэрүүд энэ хөнгөн үйлдвэрийн асуудлууд асуулаа. Энэ бол манай хүнсний хувьсгал, цагаан алт гэсэн 2 том хөтөлбөр одоо мөн Их Хурлаар батлагдаж, 2028 он хүртэл одоо хэрэгжиж байгаа үр дүнгүүд нь гарч байна. Жишээлбэл хүнсний хувьсгалын үр дүнд бид нар гол нэрийн 19 нэр төрлийн багц хүнсийг дотооддоо үйлдвэрлэх, дотоодод 100 хувь хангах, хүнсний аюулгүй байдлыг хангах бодлогын хүрээнд ингээд амжилттай хэрэгжүүлж байна. Үр дүнгүүд гарч байна. Энэ жилийн 2024 оны эцсээр гэхэд 52 үйлдвэр, 400 гаруй нэр төрлийн шинэ бүтээгдэхүүн бараа хэрэглээнд нэвтэрсэн, сонголт нэмэгдсэн.

Энэ нь бол үр дүнгүүд сая 1 дүгээр улирлын тайлангаар хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын эдийн засгийн үзүүлэх өсөлт 35.6 хувиар өсөж байгаа. Энэ тоон үзүүлэлт байгаа. Бусад бүх салбарууд хүндэрч байгаа бол энэ хүнс, хөдөө аж ахуйн салбар, хөнгөн үйлдвэрийн салбар.

Д.Жаргалсайхан: За сайн хариулъя аа гэж байна. За дахиад нэг юм нэмчихье. За ингээд 4 дэхээ нэмж байна шүү сайд аа.

Ж.Энхбаяр: Тэр 35.6 хувийн өсөлт гэдэг бол энэ Их Хурлын баталсан бодлогууд амжилттай хэрэгжсэн үр дүнгүүд л одоо гарч эхэлж байна. Мөн Цагаан алт хөтөлбөрийн хүрээнд арьс шир, ноос ноолуурынхаа үйлдвэрүүдийнхээ боловсруулсан түвшнийг сайжруулах томоохон ажлууд хийгдэж байна. Энэ жилийн хийсэн нэг том ажил бол бид ноолуураа Монгол Улс дотооддоо 100 хувь самнадаг болсон. Урьд нь түүхий гаргадаг байсан бол 100 хувь угаагаад, 100 хувь самнадаг болж байгаа. Зөвхөн угаадаг, самнадгийн хооронд 700-гаад тэрбум төгрөгийн нэмүү өртөг Монголд татвар, ажлын байр, орлого болж үлдлээ.

Манай ноосон ноолуурын, арьс ширний үйлдвэрүүд эргэлтийн одоо болон хөрөнгө оруулалтын зээлээ авцгаасан. Ингээд үйлдвэрлэлийн өргөтгөлүүд шинэ шинэ шугамын юмнууд нэлээн амжилттай хэрэгжиж байна. Ноолуур дээр их том ахиц гарсан. Одоо ноосны ажил эхэлж байна. Ингээд 6, 7 сар ноос бэлтгэл. Ингээд 8, 9 сараас бид нар арьс шир, мал, махны ажил руугаа орно буюу үйлдвэрлэлийн суурь чадавхууд энэ хөтөлбөрийн хүрээнд өссөн. Тэгээд үр дүн саяын энэ эдийн засгийн үзүүлэлтээр гарч байна. 2 дугаар улиралд бүүр их...

Д.Жаргалсайхан: За баярлалаа тодруулах уу? За Батбаяр гишүүн шууд өгье.

Д.Батбаяр: Сангийн яамнаас ахиад тодруулчихмаар байна. Нөгөө бид нар чинь гүйцэтгэлээ хэлэлцэж байгаа учраас, эргэлзээтэй байгаа мэдээллүүдийг гялс тодорхой гялс хэлээд явчихвал зүгээр байна. Тэгэхээр ямар ямар зээлүүд дээр ямар төслүүд дээр бид нар хаана хаанаас зээл авсан байгаа вэ гэдгийг товч бөгөөд тодорхой хэлээд аль нь ингээд ингээд гацсан байгаа, аль нь цаашаа үргэлжилж байгаа вэ? зээл тусламж шүү гээд хэлчихмээр байна 1 дүгээрт нь.

Дахиад, бас нөгөө Сангийн яаман дээр бас бид нар нөгөө юуг бусдаар мэдээлэл авч байхад бас ярьж байсан. Энэ нөгөө бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөрүүд маань арай өөрөөр тайлагнадаг болоод ингээд ирчхэж байгаа юм байна. Тэр маань одоо энэ үндсэн үйл ажиллагааны зардал энэ тэр гээд мөн гэх мэтчилэнгээр нэг тодорхой хэмжээний зарим зардлууд энд тусгагдахаа байчхаж байгаа юм байна шүү дээ тийм үү? Энэ ямар учраас ингэсэн байна? Ямар тушаалаар, ямар байдлаар ингээд жижгэрээд ороод ирж байна. 2024, 2025 он чинь 2 ялгаатай болчихсон байх шиг байна шүү дээ. Би энэ тодотголоос хараад л сууж байна л даа.

Д.Жаргалсайхан: За хэн хариулах вэ. Дэлгэржаргал 6 номер.

Ж.Дэлгэржаргал: Батбаяр гишүүний асуултад хариулъя. Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газар Дэлгэржаргал. За одоо яг Улсын Их Хурлаар соёрхон баталсан хэлэлцээр нь батлаад, хэрэгжилт рүү орж ирсэн 18 хөгжлийн түнш байгууллагын зээлийн төсөл хэрэгжиж байгаа. За өнгөрсөн онд бид нар 116 төслийг хэрэгжүүлсэн. Энэ 2025 оны төсвийн ашиглалт дээр бол 89 төсөл явж байгаа. Энэ дотроо 18 хөгжлийн түнш дотроо бол амлалтын дүнгээрээ хамгийн өндөр нь бол Энэтхэгийн Эксим банк, Газрын тосны боловсруулах үйлдвэр байгаа. Төслийн тоо.

Дараагийн одоо хөгжлийн түнш бол Азийн хөгжлийн банкны төслүүд байгаа. 30 гаруй төсөл хэрэгжиж байгаа. Азийн хөгжлийн банк бол илүү дэд бүтцийн салбарт бол томоохон бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтууд хийгдээд явж байгаа. Одоо яг энэ 89 төслийн зээлийн ашиглалтын үлдэгдэл нийтдээ 12.6 их наяд байгаа. 12.6 их наядаас бид нар энэ жил төсөв дээр болон тодотголд өргөн барьсан дүн маань өөрчлөлтгүй буюу 1 аравны.

Д.Жаргалсайхан: За баярлалаа. Ингээд Ганзоригийн Лувсанжамц гишүүн асуултаа асууя. За 6 номер дээр ахиад нэг минут өгчих өө. Лувсанжамц гишүүний цагийг болиулчих тийм.

М.Санжаадорж: Сангийн яам Санжаадорж. Гишүүний асуултад хариулъя. Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж болбол өөрөө бол энэ эдийн засгийн ангиллын хувьд болбол нөгөө гуравдагч этгээдээр гүйцэтгүүлж байгаа асуудал байгаад байгаа. Гэхдээ болбол Улсын Их Хурал дээр бол хэлэлцэж байх энэ шатанд болбол энэ өөрөө бас илүү тодорхой болох ёстой гэдэг ийм асуудал яригдаад, нөгөө талдаа бол бид болбол 2026 оноос бол энийг ер нь зөвхөн хувийн хэвшлээр гүйцэтгүүлж байгаа эдийн засгийн ангилал байх байдлаараа одоо зардлыг, зориулалтыг нь өөрчилж оруулж ирэх ийм бодлого бол барьж байгаа.

Яг түрүүний таны асуусан тэр мал амьтантай холбоотой жишээ нь вакцинтай холбоотой зардал гэхэд болбол Мал амьтны энэ эрүүл мэндийн тухай хуулиар болбол халдварт гоц халдварт өвчнүүдээр ялгаж байгаа. Хуулиараа. Жишээ нь болбол аль хэсгийг нь улсын төсвөөс хариуцах вэ, аль хэсгийг нь орон нутаг хариуцах вэ, бусад одоо аль хэсгийг нь малчин өөрөө хариуцах вэ гэдэг асуудал байгаад байгаа. Тэгээд хэдэн хувийг нь хаанаас төлөх вэ гээд. Тийм учраас илүү нарийвчлахын тулд бол бид нар яг хуулийн хэлээр нь тэр зориулалтуудыг бол оруулж ирчхээд байгаа юм.

Д.Жаргалсайхан: За баярлалаа. Лувсанжамц гишүүн.

Г.Лувсанжамц: Бүх яамдууддаа, гишүүддээ өглөөний мэнд хүргэе ээ. Нэг жилийн өмнө бид нар 2023 оны гүйцэтгэлийг ярьсан. Тэрэн дээр нэг зүйлийг хэлсэн. Үрж дууссан мөнгөө тайлагнаж болохгүй ээ, ямар үр дүнд хүрснээ ярих ёстой гэж хэлээд нэг ийм экселийн ийм хүснэгт гаргаж ирчхээд, 2 тэрбум төгрөг төсөвлөсөн, 2 тэрбум үрж дууссан, гүйцэтгэл 100 хувьтай гээд ийм байдлаар Монгол Улс хөгжих боломжгүй.

Төсвийн 1 дүгээр хавсралт гэж тэрийг л бид нар ярих ёстой, тэрнийхээ тайлангаа л тавих ёстой. Энийг одоо хэд хэлүүлэх юм. Татвар төлөгчид үр дүнд хүрээч ээ, үр дүн гаргаач ээ, иргэдийн нийгмийн эдийн засгийн орчныг сайжруулаач ээ гээд татвар төлж байгаа. Өөдөөс нь мөнгийг нь үрээд дуусгачихсан, 100 хувь үрээд дуусчихсан, бид нар сайн ажиллалаа гэсэн нэг иймэрхүү л тайлан гараад байгаа. Жилийн өмнө яг адилхан зүйл хэлсэн. Жилийн дараа яг энэ бахь байдгаараа л орж ирж байна.

2024 оны улсын төсөв нийт 39 төсвийн ерөнхийлөн захирагчдын хөтөлбөрт нийт 412 шалгуур үзүүлэлт багтсан 1 дүгээр хавсралт дээр нь. Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газраас асуумаар байна. Энэ 412 шалгуур үзүүлэлт ямар үр дүнтэйгээр биелсэн юм бэ? ямар үр дүнд хүрсэн юм энэ нэг төсвийг 2024 оны төсөв дээр зарцуулсан бүх мөнгө.Тэрийг асуумаар байна.

2 дугаарт Монгол Улсын Ерөнхий аудитороос. Хавсралт 1-ийн 10.1.1 Аудитын чанарыг сайжруулна аа. 10.1.1.4 Гүйцэтгэлийн аудитын үр өгөөжийг 2022 оны түвшнээс нь 3 хувиас илүүгээр сайжруулна аа гэсэн. Энэ үр дүндээ хүрч чадсан уу?

2 дугаарт Сангийн сайдаас асууя. 24.1, 24.1.1.Төсвийн ил тод байдлыг нэмэгдүүлнэ, 24.1.1.1 олон улсын төсвийн нээлттэй байдал үнэлгээг 60 оноог байгааг 60-аас дээш болгоно гэсэн зорилт тавьсан. 2024 оны эцсийн түвшинд хэдэн оноотой байсан бэ?

Монгол Улсын Шадар сайдаас асууя. 19.1.1.Гадаад худалдааг хөнгөвчилж, экспортын үйл ажиллагаанд зарцуулж байгааг хугацааг нь бууруулна. 2022 оны түвшинд 302 цаг зарцуулдаг байсан бол, 72 цаг болгож бууруулна гэсэн. Энэ одоо хэдэн цагтай байна аа? 2024 оны байдлаар.

Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдаас 29.1.3 ашигт малтмалын ордуудын ашиглалтыг нэмэгдүүлнэ ээ, 29.1.3.7 Алт тушаалтны хэмжээг 20 тэрбум жилд хүргэнэ тэрнээс дээш болгоно. Газрын тосны экспортын хэмжээг 4.7 сая тэрнээс дээш болгоно. Ямар үр дүнд хүрсэн бэ?

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдаас асууя. Бэлчээрийн даац, тэжээлийн нөөцийг нэмэгдүүлнэ. 30.1.1.2 Нийт бэлчээрт даац хэтэрсэн бэлчээрийн эзлэх хувийн жинг 57.5 болгож бууруулна. Гол нэрийн зарим хүнсний бүтээгдэхүүний улирлын хэлбэлзлийг бууруулна. 30.3.1.1 Сүүн бүтээгдэхүүний дотоодын хангамжийг 65.3 хувь болгож нэмэгдүүлнэ. 2024 оны байдлаар ийм үзүүлэлтүүд ямар түвшинд хүрсэн юм бэ, ямар үр дүнд хүрсэн юм бэ гэдгийг асуумаар байна.

Д.Жаргалсайхан: Ингээд 6, 7 ч асуудал болчихлоо. За Учрал сайдын микрофоныг.

Н.Учрал: Тийм энэ үнэлгээний асуудал дээр Лука гишүүний энэ яриад байгаа асуудал болбол яг л одоо миний бодож, миний сонссон, миний ойлгож байгаа, хувийн хэвшилд ажиллахдаа мөрдөж байсан зүйл л дээ. Тэгээд төр гэхээрээ өөр байж болохгүй. Тэгэхээр Лука гишүүний ярьж байгаа энэ үнэлгээний аргачлалыг бодит утгаар нь хэрэгжүүлэхгүй бол яг л нэг ийм л дүгнэлтүүд тавиад байгаа юм. Тодорхой бус, хэмжиж болдоггүй. Одоо нэг ийм ойлгомжгүй. Тэгээд ерөөсөө л энэ Засгийн газрын үйл ажиллагааны төлөвлөгөөн дээр ч тэр, 4 жилийн хөтөлбөр дээр ч тэр загварчлаад, мониторинг хийгээд, үнэлгээгээ хийгээд, тэгээд эргээд одоо хариу арга хэмжээг авдаг ийм л одоо механизмаар явах ёстой. Гэтэл одоо тэгж байгаа юм болбол байхгүй.

Тэгээд улсын жилийн төлөвлөгөө гэдэг чинь хүслийн жагсаалт болчихсон байгаа шүү дээ. Хүслийн жагсаалт. Хэзээ ч биелэгдэхгүй мөрөөдөл хүслийн жагсаалт. Энэ чинь Их Хурал дээр орж ирээд хэлэлцэгддэг, санал гаргадаг, тэгээд тэрэндээ хэзээ ч хүрдэггүй. Тэгээд бид нар нэг ийм Байнгын хороон дээр орж ирээд гүйцэтгэл ярихдаа ингээд нэг тайлагнадаг. Тэгэхээр чинь ингээд шинэ гишүүд орж ирэхэд гайхахаас аргагүй шүү дээ энэ чинь. Хувийн хэвшилд ажиллаж байсан хүмүүс өөрөөр харж байгаа.

Тэгэхээр зүгээр хяналт хэрэгжүүлэх газар гэдэг газрыг яагаад Эдийн засгийн хөгжлийн яам руу Ерөнхий сайд Занданшатар шилжүүлэе ээ гээд шийдсэн юм бэ

гэхээр энэ үнэлгээг л бодит болгоё гэж байгаа юм. Жилийн төлөвлөгөө, 4 жилийн хөтөлбөр, 5 жилийн үндсэн чиглэл. Тэгэхээр жилийн төлөвлөгөө дээр ч байгаа. Гадаад худалдааны нэг цахим цонхтой болно гэж. Одоо биелсэн юм уу. Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газар гээд газар хаана байна? Тэд нар та нар нэг баахан материал бүрдүүлж өгсөн. Тэрийг чинь хүн хараад ойлгохгүй л юм байна лээ. Хэдэн онд ч тийм юм хийдэг байсан юм. Зүгээр хяналт хэрэгжүүлэх газар Эдийн засгийн хөгжлийн яаман дээрээ шилжсэнээрээ би зүгээр нэг зүйлийг хэлэхэд гадаад худалдааны нэг цонхтой болно.

Сая одоо эндээс Батбаяр гишүүн асууж байна. Гадаад зээлийн ашиглалт дээр 39.5 тэрбум төгрөг байгаа юм бол энэ гадаад зээлийн ашиглалт дээр мониторинг хяналтын функц ажиллуулна аа. Цахимын сайдаар ажиллаж байсан учраас Хэрэг эрхлэх дээр ирснийхээ дараа энэ И кабинетыг ингээд рийл таймаар бид нар экспорт хардаг болсон шүү дээ. Тэгвэл яагаад энийг мониторинг хийхгүй байгаа юм. Мониторинг хийгээд үнэхээр тэр энэ Лувсанжамц гишүүний ярьж байгаа тэр 302 цаг чинь 72 цаг болж байгаа үгүйг гайхаад байх юм байхгүй шүү дээ. Рийл таймаар ингээд дэлгэц дээр харахаар харагдаж байгаа шүү дээ. Хэдэн цаг яаж багассан юм. Ингээд үнэлчих юм болбол бид нар яг энд цаг алдаад байх ч юмгүй болно цаашид.

Тийм учраас хяналтын функц ажиллуулна аа. Үнэхээр зөвшөөрөл 30 хувиар бууруулна аа гэж бид нар зорьсон бол энгийн зөвшөөрлийг мэргэжлийн холбоонд өгнө өө гэж жилийн төлөвлөгөөнд тусгасан бол яг буурч байгаа эсэх дээр бид нар хяналтын функцээ ажиллуулах л ёстой. Зөвшөөрөл хаана гацаагаад байгааг бид нар харж чаддаг болсон. Тэгвэл яагаад Гаалийн ерөнхий газар 302 цагийг 72 цаг болгож бууруулахгүй байгаа юм. Бууруулж чадахгүй гээд юм болбол яах гэж жилийн төлөвлөгөөнд тусгасан юм. Тэгэхээр 72 цаг бууруулахад хэн газ гацаад саад тотгор учруулаад байгаа юм бэ гэдгийг бид нар бодит цагаар харж байгаад Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газар хянан шалгалт хийнэ ээ.

Төрийн хүнд суртлын бууруулах, бизнесийн хүнд суртлыг бууруулах асуудлыг хэн нэгнээс асуухгүйгээр жилийн төлөвлөгөөнд тусгачихсан ажлуудыг хийх эрх сая энэ Тэргүүн шадар сайд дээр ирсэн. Тийм учраас ирэх жил болбол бид нар энийг одоо гадаад худалдааны нэгж цонхтой болгоод яг тэдэн цагаар буурсан гэдгийг болбол яг хэмжигдэхүйц байдлаар тайлагнадаг ийм загвар луу шилжинэ ээ гэдгийг би бас хэлэх ёстой байх гэж бодож байна. Тэгээд үнэлгээ мониторингийн функцийг ажиллуулдаг зөв жишиг рүү одоо явахын төлөө энэ 5 жилийн чиглэл ч бай, жилийн төлөвлөгөө ч бай амьдрал дээр одоо биеллээ олох болно оо гэдгээ хэлье.

Д.Жаргалсайхан: Энхбаяр сайд хариулж байх уу? Тэр хооронд Жавхланбаатар асуудал хэлэлцэж байгаарай. Танаас асуулт асуусан шүү.

Ж.Энхбаяр: Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам 5 зорилтыг 13 шалгуур үзүүлэлтийг хангах ийм үүрэгтэйгээр ажиллаж байгаа. Асуулт 1 дүгээрт бэлчээрийн даац, бэлчээрийн даацыг бид нар 60.5 хувь байгааг 60.5 хувьд одоо бэлчээрийн даацыг ачааллыг бууруулах ийм үзүүлэлттэйгээс дүн 57.5 хувиар гарсан. Яагаад энийг бууруулж, юу хийгээд бууруулчхав аа гэдэг асуудал. 1 дүгээрт малын экспортыг бүх талаар урамшуулсан. Мал, махны экспорт дээр байсан квот, тусгай зөвшөөрөл, бүх хязгаарлалтыг тэглэсэн. Нөгөө талаар гадаад улс оронтой хийх бүх гэрээ, протоколуудыг нь хийж баталгаажуулсан. Ингээд бид 2 жилийн

хугацаанд 180 мянган тонн мах буюу хонин толгойд шилжүүлэхэд нэг 9 сая гаруй толгой малыг экспортод гаргаж чадсан.

Д.Жаргалсайхан: Нэмэлт хариулна. Энхбаяр сайдын микрофон.

Ж.Энхбаяр: 2 дугаарт махны экспортыг идэвхжүүлэхтэй холбоотойгоор орон нутаг сумдуудтай хамтраад ажиллаж байна. Малынхаа тоог цөөлж, ашиг шимт буюу энэ махны гол масс бүрдүүлж байгаа үхрийн одоо үхэр үржүүлэх чиглэлээр ажиллаж байгаа сумууд дээр их ахиц гарч байгаа. Нэг жишээ хэлэхэд Сэлэнгэ аймгийн Хушаат сум гэхэд 2023 он тооллогоор 132 мянган толгой малтай байсан бол сая 80 мянга болгож бууруулж байгаа юм бодлогоор. Тэгээд ямаа богоо бууруулаад, ашиг шимт үхэр сүргийнхээ тоог нэмж байгаа. Тэгээд сумаараа тэр чигээрээ бид нар махны хэв шинжийн одоо үхэр үржүүлж, махны зах зээл дээр гол одоо нийлүүлэгч бол сум болно гэдгээ бодлогоо тодорхойлоод, энэ салбарын яамтайгаа ажиллаж байгаа.

Нөгөө талаас энэ бэлчээр хамгаалах, ургамал хамгааллын байгууллага ажиллаж байна. Шавж, мэрэгч ургамлын тэр хөнөөлт бусад төрлийн өвчинтэй тэмцэх энэ арга хэмжээ яг мэргэжлийн түвшинд хийгдэж, өргөн хүрээг хамарч эхэлж байна. Энэнтэй холбоотойгоор бэлчээрийн хамгаалалтын ажлууд бас их...

Д.Жаргалсайхан: Бас нэмээд өгчхөөрэй. Энэ хариулт бас тодорхой хариулах нь их сайн байна.

Ж.Энхбаяр: Сүүн бүтээгдэхүүн дотоод хангамж бид нар суурь үзүүлэлт 2021 онд 62.2 хувь байсан. Одоо 65.3 хувь, энэ жоохон удааширч байгаа хэдий ч бид арга хэмжээнүүдийг хийж байна. Одоо энэ 7, 8, 9 сард багтаад нэг 1800 орчим сүүний ашиг шимт цэвэр үйлдвэрийн үнээнүүд Монгол Улсад орж ирж, аж ахуйн нэгжүүд дээр очихоор ийм гэрээ хэлэлцээртэй явагдаж байна.

Манай энэ атрын 4 гэсэн аяны хүрээнд газар тариалан, мал аж ахуйг төгс хослуулах эрчимжсэн аж ахуйнуудыг хөгжүүлэх чиглэлээр ийм дэмжлэгийн зээлийн бодлогыг дандаа энд чиглүүлж байгаа. Ингээд малыг сайжруулах, нэг малаас авах ашиг шим нэмэгдүүлэх ажлууд явж байна. Жишээлбэл одоо сүүний үхэр дээр гэхэд манайд нэг 70-аад мянган саалийн үхэр байна. Энийг одоо ашиг шимт байдлыг нь дээшлүүлснээр бид 25 мянган үнээтэй байхад л хэрэглээгээ хангах хэмжээтэй. Тэгэхэд цаана нь 50 мянгын толгойгоор бид буулгаад, бэлчээрийн даатгал тэжээлийн зардлаа буулгаад, үр ашигт байдал руугаа анхаарах маягаар ийм эрчимжсэн аж ахуйнуудаа ингэж...

Д.Жаргалсайхан: Аудитын чанарын талаар гэсэн Ерөнхий аудитор хариулт 2 номер шүү.

С.Магнайсүрэн: Лувсанжамц гишүүний асуултад хариулъя. За 1 дүгээрт энэ аудитын чанарыг сайжруулах талаар манайх бол өдөр тутам анхаараад, бодлого стратегидаа тусгаад ингээд ажиллаж байна. Өмнө нь бол жилд нэг 15-17 сэдэв чиглэлээр аудит хийдэг байсан гүйцэтгэлийн аудит. Одоо бол бид нар 2 дахин ихт буюу одоо 30 гаруйг сэдвээр бол аудит хийж байна. Бид нарын гол асуудал бол тоон үзүүлэлт гэхээсээ илүүтэй аудитынхаа чанарт болбол одоо гол бодлогоо чиглүүлж байгаа.

2 дугаарт нь 2023 онд болбол одоо нэг төгрөг тутамд 37 төгрөгийн үр өгөөжтэй ажил одоо ингэж ажилласан гэсэн ийм дүгнэлт байдаг бол одоо бид нар 2024 онд бол нэг төгрөгт 41 төгрөгийн үр ашигт, үр өгөөжтэй ингэж ажилласан гэсэн ийм дүгнэлт гарч байгаа.

Д.Жаргалсайхан: За нэмээд өгчихье дутуу явчихлаа.

С.Магнайсүрэн: Дээр нь 2023 онд бол бид нар нэг 1100 орчим зөвлөмж шийдвэрийнхээ шийдвэрээ шалгагдагч байгууллагаар хүлээн зөвшөөрүүлж ингэж ажилласан бол 2024 онд бид нар 1800, 1790 одоо зөвлөмж шийдвэрээ хэрэгжилтийг хүлээн зөвшөөрүүлж ажилласан ийм дүнтэй байгаа. Дээр нь бол Улсын Их Хурлаас өгсөн чиглэл, гишүүдийн саналын дагуу бид нар аудит хийдэг үндсэн бүтэц, чиглэлээ бол нэлээн тодорхой болгож, боловсронгуй болгосон. Тухайлах юм бол нийслэлийн аудитыг нийцлийн аудитыг бол бид нар тусдаа газар болгосон, урьдчилсан одоо аудит хийх боломжтой нэгжээ байгуулан ажиллагаанд оруулсан байж байгаа.

Түрүүний ярьдаг дээр энэ хөтөлбөрийн үр дүнгийн талаарх асуудал дээр болбол энэ улсын хөгжлийн төлөвлөгөөний хавсралт зурчихсан 408 төсөл арга хэмжээний хүрсэн түвшин, санхүүжилт 2 бол зөрөөтэй байгаа. Энэ дээр болбол одоо хяналт үнэлгээ хийгдээгүй ингэж явж байгаа нь болбол анхнаасаа төлөвлөлт төсөвлөлт нь бол бур...

Д.Жаргалсайхан: Бас дутуу байна нэмэлт өгье.

С.Магнайсүрэн: 2024 оноос хэрэгжүүлэхээр төлөвлөсөн улсын хөгжлийн төлөвлөгөөнд туссан төсөл арга хэмжээний 70 гаруй хувь буюу тодорхой хэлбэл 74.4 хувь нь болбол хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээнд төлөвлөгдсөн арга хэмжээний 74.4 хувь нь улсын хөгжлийн төлөвлөгөөтэй уялдаагүй гарсан. Дээр нь барилга байгууламжийнх нь 52.8 хувь нь одоо төсөвлөлтийн шаардлага хангаагүй буюу зураг төсөвгүй, газаргүй ч юм уу, магадлалаар юм нь баталгаажаагүй ч байдаг юм уу ийм байдлаар одоо шаардлага хангаагүй байгаа нь нөгөө төрийн хэмнэлтийн хуультайгаа бас зөрчилдсөн ийм асуудлууд байгаа юмаа.

Тийм учраас хүрэх үр дүн энэ юуг нь эцсийн үр дүнг нь одоо үнэлж дүгнэхгүйгээр энэ асуудлыг одоо цаашаа явах нь бол хүндрэлтэй юм байна аа гэдэг ийм байдлаар бид нар дүгнэлт өгөөд, зөвлөмжөө одоо хяналт үнэлгээний даргад болбол зөвлөмж, тодорхой зөвлөмж бол энэ аудитор өгсөн байж байгаа.

Д.Жаргалсайхан: За баярлалаа. Сангийн яам 5 номерыг Ганбат.

Ж.Ганбат: Монгол Улсын 2024 оны жилийн эцсийн санхүүгийн нэгдсэн тайлангийн бүрэлдэхүүн болох хөтөлбөр арга хэмжээнд зарцуулсан төсөв хүрсэн үр дүнгийн тайланд улсын төсвийн 39, орон нутгийн төсвийн 22 ерөнхийлөн захирагчдын хэрэгжүүлэх хүртэл арга хэмжээ, үр дүнгийн тайланг холбогдох журмын дагуу бол Сангийн яаманд нэгтгэсэн. Үүнд нийт 7944 хөтөлбөрийн үр дүнг нэгтгэсэн байдаг. Үүнээс 104 хөтөлбөрийн 124 үр дүн 85 хувийн гүйцэтгэлтэй, 399 хөтөлбөрийн 460-ны үр дүн 85-100 хувийн гүйцэтгэлтэй, 135 хөтөлбөрийн 209 үр дүн нь 100-аас дээш гүйцэтгэлтэй буюу нийт батлагдсан хөтөлбөрийн 84 хувь нь буюу 534 хөтөлбөр төлөвлөсөн үр дүндээ хүрсэн гэдэг ийм байдлаар бол тайлагнасан байгаа.

Нөгөө талдаа Сангийн яамнаас Олон улсын байгууллагаас үнэлдэг Монгол Улсын төсвийн ил тод байдлын оноо 2023 онд авбал зохих 100 оноос 62 оноо авч...

Д.Жаргалсайхан: Нэмэлт авах уу? За нэмэлт өгье 5 номер.

Ж.Ганбат: 2023 онд авбал зохих 100 онооноос 62 оноо авч 125 онооноос 36-д эрэмбэлэгдэж байсан. 2021 онд 60 оноотойгоор 125 онооноос 38 дугаар байранд эрэмбэлэгдэж байсан бол 2023 онд 2 байраар урагшилсан байна. Энэ үнэлгээнд ордог бүх баримт бичгээ олон нийтэд нээлттэй болгосон байгаа. Жишээлбэл хагас жилийн тайлан боловсруулж, олон нийтэд мэдээлдэг болсноос гадна төсөв боловсруулах үйл явцад иргэдийн оролцоог хангах талаар хууль, эрх зүйн зохицуулалтыг оруулж өгснөөр 2023 оны үнэлгээгээр 62 болж нэмэгдсэн. Энэ үнэлгээг 2 жил тутамд хийдэг байгаа. Тэгээд 2025 оны үнэлгээг бол ирэх жил хийх ийм байдалтай байгаа.

Д.Жаргалсайхан: За баярлалаа. Аж үйлдвэр Жавхланбаатар 4 номер.

С.Жавхланбаатар: Лувсанжамц гишүүний асуултад хариулъя. 1 дүгээр асуулт 29.1.3-тай холбоотой өнгөрсөн 2024 онд болбол бид нар сонгон шалгаруулалтыг явуулж эхэлсэн байгаа. Энэ хүрээндээ болбол хайгуулын шинээр 63 тусгай зөвшөөрөл, ашиглалтын 42 тусгай зөвшөөрөл нийт 270 мянган га газар болбол уул уурхайн хайгуул ашиглалтыг шинээр нэмж олгосон гэсэн үг. Дээр нь 2024 онд нийт 211 аж ахуйн нэгж уулын ажлын төлөвлөгөө ирүүлж баталгаажуулаад одоо үйл ажиллагаа явуулсан гэсэн ийм тайлан гарсан. Алтны тушаалтын хувьд болбол яг энэ 1 дүгээр хавсралт дээр болбол анхаарах зүйл харьцангуй бага байгаа. Улсын нийт статистикаар Монгол банканд тушаасан алтны нөөц бол 16.5 тонн. Манай энэ тайлан нь ямар учиртай юм бэ. 10.7...

Д.Жаргалсайхан: Нэмэлт өгье 4 номер.

С.Жавхланбаатар: Энэний гол ялгаа нь болбол нөгөө иргэд аж ахуйн нэгжийн ялгаа. Өөрөөр хэлбэл манай агентлаг дээр уулын ажлын алтны төлөвлөгөөгөөрөө тушаалт хийсэн тайлангаараа ингэж одоо харьцангуй бага дүн орж ирсэн. Газрын тосны экспортын хувьд болбол төлөвлөгөө 2024 онд 4.7 сая баррель байсан. 87.2 хувийн гүйцэтгэлтэй буюу 4.1 сая баррель одоо олборлож экспортолсон байгаа. Асуудал буурч байгаа асуудал гол шалтгаан болбол 2 шалтгаантай. 1 дүгээрт болбол хөрөнгө оруулагчид маань 2 хүндрэл үүссэн. Гол 3 компани дээр. Орон нутгийн эсэргүүцэл болбол тодорхой хэмжээгээр цаг хугацаагаар олборлолтыг зогсоосон байгаа.

2 дугаар шалтгаан болбол татварын маргаанаас үүдэлтэй, энэ татварын маргаанаа шийдтэл бид нар бас зарим нэмж нэмэлт хөрөнгө оруулалтыг хасна аа гэсэн ийм хөрөнгө оруулагчийн шийдвэртэй холбоотой.

Д.Жаргалсайхан: Лувсанжамц гишүүн тодруулга асуулт.

Г.Лувсанжамц: Дэлгэрэнгүй хариулсанд баярлалаа. Тэгээд ийм л юмыг Улсын Их Хурал дээр ярих ёстой, Байнгын хороон дээр ярих ёстой. Үр дүндээ хүрээд байгаа юм уу, үгүй юу гэдгээ л ярих ёстой. Ирэх жил дахиад 1 дүгээр хавсралтын тайлангүйгээр орж ирэхгүй юм биш үү. Дахиад би ирэх жил ийм юм асуугаад, ингээд нэг бүрчлэн, ингээд үр дүнг нь яам болгоноор нь асуугаад энэ 400

гаруй шалгуур үзүүлэлтийг асуугаад сууж байна гэдэг тийм цаг хугацаа ч байхгүй, боломж ч байхгүй. 1 дүгээр хавсралтын тайланг яам болгон заавал гаргаарай.

Маргааш нэгдсэн чуулган дээр энийг бас ярилцана. Би дахиад бусад яамдуудын энэ 1 дүгээр хавсралтын хүрсэн үр дүнг, хүрч чадаагүй бол яагаад хүрч чадаагүй гэдэг зүйл Уул уурхайн яам бол сая тодорхой хариуллаа шүү дээ. Яагаад экспортод зорьсон түвшиндээ хүрээгүй юм бэ? Ямар шалтгаан байгаа юм. Тэр шалтгаанаа дараа нь бид нар асуудлаа тодорхойлж байгаад шийддэг шийдэл ярьж чаддаг ийм төр болох ёстой. Тэгэхлээр та хэд маань ирэх жил энэ дээр сайн анхаараасай гэж хүсэж байна.

Д.Жаргалсайхан: За баярлалаа. Ингээд Ганбатын Очирбат гишүүн асуултаа асууна.

Г.Очирбат: Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хороонд харьяалах 2 яамны бас ерөнхий дүгнэлтүүд орж ирсэн байна. Тэгээд энэ аудитын газраас жил болгон л дүгнэлт орж ирдэг. Тэгээд энэ дээр ч гэсэн бас ороод л ирсэн байна. Санхүүгийн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамтай холбоотой 253 тэрбум төгрөгийн залруулагдаагүй зөрчил илэрснийг дүгнэсэн байна. Эрдэс баялаг, аж үйлдвэрийн яам дээр 316 тэрбум 46 сая төгрөгийн санхүүгийн зөрчлийн аудитын тайланг бас хэлсэн байна. За урьд урьдын жилүүдэд зөвлөмжөөр өгч байсан ажлуудын үр дүн муу байна гээд ингээд жил болгон л ярьдаг. Тэгээд энийгээ яаж сайжруулах вэ одоо. Түрүүн Учрал сайд байсан, Тэргүүн шадар сайд, Сангийн сайд байсан, гараад явчихсан юм уу.

Сангийн яамны ер нь энэ асуудлууд хаана байгаа юм бэ гээд бас Булгантуяа даргаар ахлуулаад бид нар энэ төсвийн цаглавартай холбоотой ажилласан юм. Асар их олон хууль тогтоомжийн давхцалууд байгаа. Энийгээ арилгаж чаддаггүй, зоригтой ажил хийж чаддаггүй. Өчигдөр Ёс зүйн дэгийн байнгын хороон дээр бас Жавхлан сайд хэлсэн 42 хуулийг бид нар өргөн барих гээд бэлдчихсэн байгаа. Ганцхан хууль буюу төрийн албан хаагчтай холбоотой хуулийг өргөн барихад МАН-ын бүлэг дээр унасан. Хуулиа эргүүлэн татсан. Тэгээд энэ 42 хууль буюу энэ хуулийн давхцал буюу давхацсан чиг үүргүүдийг арилгахгүй бол цаашаагаа энэ завхрал чинь байхгүй болохгүй ээ.

Сүүлийн 30 жил хүн болгон дураараа тоглоод, хүн болгон өөрөө хууль санаачлаад, тэрийгээ батлуулах гэж гүйж Их Хурлын гишүүдийг лоббидоод, тэрийгээ батлаад, тэр нь төсөв дээр дандаа дарамт болж ирдэг тийм нөхцөл байдал үүсчихсэн. Тэгээд энэ Сангийн яамнаас гаргасан энэ зөвлөмжийг бас Их Хурлын гишүүддээ бас энэ индэр дээрээс уриалах гэсэн юм. Уншиж танилцаасай. Энэ нийтлэг хэм хэмжээг салбар бүр тусдаа хуулиар зохицуулах хандлага нэмэгдээд байгаа юм. Энэтэй холбоотой 17 хуулийн төсөл байгаад байгаа. Хуулийн замбараагүй зохицуулалт нь төрийн албан хаагчийн хооронд орлогын ялгаатай байдал үүсгэж байна гээд бүүр гаргаад ирчихсэн. Бас 10 хэдэн хууль давхацчихсан. Төрийн албан хаагч нар 6 өөр үндсэн цалин авдаг болсон. Хэн лоббитой, хэн эрх мэдэлтэй, хэн түрүүлж том яамны сайд болно тэр хуулиа батлуулаад салбарынхаа цалинг дураараа нэмдэг, бусад төрийн албан хаагч нараа боддоггүй ийм байдал руу орсон.

Төсвийн орлогыг урьдчилан болон тусгайлан хуваарилах хандлага бий болж байна гэж байгаа юм. Олоогүй байгаа орлогыг шүү дээ. Хууль эрх зүйн орчин нь

байна. Энгийг өөрчлөх ёстой. Үр ашиг багатай, хүнд суртал, шат дамжлагыг нэмэгдүүлэх нөлөөтэй зохицуулалт байсаар байна аа гээд байгаа юм. Зөвлөмж өгөөд Сангийн яамныхан хэлээд байхад...

Д.Жаргалсайхан: Очирбат гишүүн дээр нэг минутын тодруулга.

Г.Очирбат: Тэгээд Тэргүүн шадар сайд, Учрал сайд, залуу хүн сайд болсон. Асуух гээд байсан гээд хаашаа гараад явчлав аа. Яг түрүүн өөдөөс хараад сууж байсан. Энэ хуулийн төслүүдээ засгаасаа оруулж ирж чадах юм уу, чадахгүй юм уу. МАН-ынхан энэ хуулийн төслүүдээ дэмжээд цаашаа явж чадах юм уу, чадахгүй юм уу. Төрийн хүнд суртлын энэ замбараагүй зардлаа танаж чадах юм уу, чадахгүй юм уу? Нэгдсэн бодлого зохион байгуулалтад орж чадах юм уу, чадахгүй юм уу? Сангийн яамныхны энэ өгөөд байгаа мэргэжилтнүүдийн өгөөд байгаа Үндэсний аудитын газрын энэ төсвийн тогтвортой байдлынхны өгөөд байгаа зөвлөмжийг хэрэгжүүлээд ажиллаж чадах юм уу, чадахгүй юм уу. Чадахгүй бол бид энд суугаад байх шаардлага байхгүй. Жавхлан сайд ороод ирлээ.

Өчигдөр бид 2 яг ярьсан 42 хуулийн төсөл бэлэн байгаа гэсэн. Би энэ индэр дээрээс МАН-ын гишүүдэд энэ хуулийг дэмжээд өгөөч ээ. Асар олон энэ хуулийн чиг үүргийн давхцалыг чинь арилгах гээд мэргэжлийн Сангийн яамныхан ажиллаад байна аа. Тэгээд энэ чиглэл зааврыг нь аваад ажиллаад өгөөч. Тэргүүн Шадар сайд Учрал сайд энгийг ажил болгоод Их Хурал руу оруулаад ирээч, дэмжээд...

Д.Жаргалсайхан: Сангийн яамнаас хэн хариулах вэ? Жавхлан сайд.

Б.Жавхлан: Очирбат гишүүний асуултад хариулъя. Ер нь төсвийн реформ, зардлын реформ хийх орон зай ер нь аягүй хязгаарлагдмал. Энэ ямар утгаар хэлж байна вэ гэхээр саяын гишүүний дурдсан ер нь яах вэ бид сая судалгаа хийгээд эхний ээлжид нэг 42 хуулийн өргөн барихаар бэлдчихсэн байгаа юм. Энэ болбол Улсын Их Хурал, Засгийн газар хоёрын хооронд явж байгаа асуудал шүү. Бид ноднин төсвийн үеэр үүрэг аваад сая 4 сард энэ судалгаагаа Их Хуралд өргөн барьчихсан танилцуулчихсан. Одоо эргээд Их Хурлаас Засгийн газар өөрсдөө шийдээд эрэмбэлээд оруулаад ир ээ гэхчихсэн байгаа.

Ингээд сая тодотголын үеэр бид нэг 42 хуулиар нийтдээ нэг бараг 5 их наяд төгрөгийн ийм аль хэдийнэ зардлыг төсөвт хуваарилчихсан ийм заалтууд дээр одоо эргэж харъя аа гэдэг ийм санал бэлдсэн байгаа. Тодотголтой давхцаад ороод ирэхээр үнэхээр цаг хугацааны хувьд тодотголоо ч хийж амжихааргүй байсан. Тийм учраас түр хойшлуулаад ирэх оны төсөвтөө цуг өргөн барина аа. Тэрийг хийхгүйгээр бид нар одоо төсөв дээрээ реформ хийнэ гэдэг ойлголт ерөөсөө хаана ч байхгүй, ямар ч боломж байхгүй. Тийм учраас энгийг хэлэлцэх үед одоо салбар салбарын олон хамгаалагч гарч ирэхгүйгээр яг үнэхээр төсвийн реформ гэдэг тугаа мандуулаад энгийг бүгдээрээ одоо энэ Их Хурал хийнэ ээ гэдэгт би одоо бас найдаж байгаа шүү гэдгийг хэлье.

Д.Жаргалсайхан: Очирбат гишүүн тодруулах нэг минут өгье.

Г.Очирбат: Аудитынхан шинэ дарга маань яах вэ орчихсон, Наранчимэг дарга бас энгийгээ нээлттэй ил ярих хэрэгтэй шүү. Бид нар өрөөнд суугаад юм ярихдаа яг энэ зарчмаа яриад тохирдог тиймээ. Төрийн албан хаагч нартай холбоотой асуудлууд, энэ хууль хэрэгжилтийн давхцалын асуудлууд, аудитын

газраас өгч байгаа энэ дүгнэлтүүдийг хэрэгжүүлэхгүй байгаа асуудлууд, зөвлөмжүүд дүгнэлт өгөөд байхад жил болгон ингэж оруулж ирдэг. Энэ дээрээ хойшдоо хариуцлагатай байхгүй бол энэ парламент бол 80 хэдэн залуу Их Хурлын гишүүдтэй бас нэг энэ зөв голдирол руу нь оруулах тэр талд нь ажиллачихъя гэж зүтгэж байгаа. Тэгээд яг ийм байдал дээр байвал бас шантрах гээд байна шүү үнэнгээ л хэлье.

Үгүй ээ нээрээ, яг тэгж байна шүү. Бид нар чинь нэг жилийн хугацаанд ёстой үзээгүй бүх юмаа л үзлээ, засгаа унагааж үзлээ. 2 тодотгол үзэж байна гээд л асуудлууд зөндөө үзэж байна шүү. Тэгэхээр одоо энэ хийх ёстой ажлуудаа урагшаа хараад хийгээд явмаар байна аа. Тэгэхгүй мэргэжлийнхээ хүмүүсийн зөвлөгөөг авдаггүй, тэгээд дандаа л лобби, дандаа л ар тал дээр нь үр дүн муу гарсан юмнууд ингээд л яриад л сууж байдаг.

Д.Жаргалсайхан: За баярлалаа. Ингээд Даваахүүгийн Пүрэвдаваа гишүүн асуулт асууна аа.

Д.Пүрэвдаваа: Энэ өдрийн мэндийг хүргэе ээ. Өнөөдөр 2024 оны төсвийн гүйцэтгэлийн асуудал хэлэлцэж байгаа. Тэгээд энэ Үндэсний аудитын газраас тарааж өгсөн материалтай танилцахад 131 дүгээр хуудсанд татварын байгууллагаас татварын бүрдүүлэлт, ногдуулалттай холбоотой зөрчил, гэрээ, бараа, ажил үйлчилгээ, мөнгө угаасан байж болзошгүй нийт 7 тэрбум 319.5 тэрбум төгрөгийн 7 их наяд юм байна. 319 тэрбум төгрөгийн гэмт хэргийн шинжтэй асуудлыг хууль хяналтын байгууллагад шалгуулахаар шилжүүлсэн нь татварын нийт орлогын 26.7 хувьтай тэнцэж байна аа гэсэн байна. Энэ одоо 30 их наядын төсөв баталсан тодотгоод, жишээ нь 7 их наядын мөнгө угаасан байж болзошгүй гэдэг энэ өгүүлбэрийг хараад одоо би бол их цочирдож байна аа. Тэгээд нэлээн зузаан ч тараах материал байсан юм. Энийгээ нэг тайлбарлаж өгөөч ээ.

2 дугаарт энэ бизнес эрхлэгчдээ бол үнэхээр дарамталж байгаа нь одоо бас тодорхой хэмжээнд харагдаад байгаа юм. Хугацаа хэтэрсэн, насжилт өндөртэй татварын өр гэж байгаа юм. НӨАТ 550 тэрбум, АМНАТ 413 тэрбум, аж ахуйн нийт нэгж орлогын албан татвар 154 тэрбум байна аа. Энэ компаниудынхаа дансыг хаадаг, энэ татварын өр байгаад байдаг яг эсрэгээрээ нөгөө талд нь төр маань данхайгаад ялангуяа энэ дарга нар бол 3 эрх мэдэл хүсдэг юм шүү дээ. Нэг нь болохоор хүний нөөцийн мэдэл, 2 дахь нь болохоор төсвийн мэдэл, 3 дахь нь тэр зөвшөөрөл лицензийн мэдэл. Ийм 3 төрлийн мэдэл үндсэндээ зонхилдог. Тэгээд төсвийнхөө мэдлийг дээд цэгт нь хүртэл нь тэлсэн. Хүний нөөцийнхөө мэдлийг дээд цэгт нь хүртэл тэлсэн. Эрх баригч нам, Хүн нам одоо АН нийлж байгаад одоо хурдан хөгжил гээд нэг шинэ 30 жилийн эхлэл гэсэн. Тэгээд шинэ 30 жилийн эхлэл чинь тэгээд ийм мөнгө угаасан хэлбэрээр эхэлдэг юм уу? нэг тайлбарлаж өгөөч. Тэгээд энэ аж ахуйн нэгжийнхээ өрийг яах гэж байгаа юм. За баярлалаа тодруулна аа.

Д.Жаргалсайхан: Хариултыг нь өгөх үү. Аудит уу, ерөнхий аудитор уу, хариулт өгөх үү. За Магнайсүрэн 2 номер.

С.Магнайсүрэн: Энэ татварын байгууллагын одоо тайлан мэдээлэл, мэдээлэл эх сурвалжаас одоо манайх дүгнэсэн байж байгаа. Тэгэхээр бодит үйл ажиллагаа одоо манайд юун дээр үзэх юм бол гэмт хэргийн шинжтэй байж болзошгүй НӨАТ-ын хий бичилттэй холбоотой 950 тэрбум төгрөг, бусад гэрээ бараа, ажил үйлчилгээ, мөнгө угаасан байж болзошгүй 6.3 их наяд төгрөг, нийт 7.3

их наяд гэж гарч байгаа. Үүн дотор бодит үйл ажиллагаа явуулаагүй их хэмжээний борлуулалтын падаан шивж НӨАТ одоо яасан шивсэн. Мөн их хэмжээний цахим төлбөрийн баримт худалдан авсан, гэрээ болон бусад үйл ажиллагаа энэ тэр гээд ингээд Татварын газрын одоо мэдээллээс ингэж дүгнээд энэ Татварын газрын хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн энэ нийт дүн нь одоо 26.7 хувийг эзэлж байна аа гэсэн ийм дүгнэлтийг бол хийсэн байж байгаа.

Тийм Цагдаагийн ерөнхий газар, Эдийн засгийн одоо гэмт хэрэгтэй тэмцэх газартай манайхан тулгалт хийж, энэ тоо гарч ирсэн байгаа. Тэгээд нарийн одоо тайлбарыг бол бас татварынх, татвараас асуувал илүү дэлгэрэнгүй тайлбар өгөх байх аа.

Д.Жаргалсайхан: Нэмэлт Сангийн сайд хариулах уу. Өөр хүн байна уу? За тэгвэл тийшээ очиж суугаарай. 6 номерын микрофон.

Р.Мягмаржав: Пүрэвдаваа гишүүний асуултад хариулъя. Татварын ерөнхий газрын Татвар хураалт удирдлага, арга зүйн газрын дарга Мягмаржав. Татварын байгууллагаас ерөнхийдөө татвар төлөгчийн үйл ажиллагаанд нь хяналт шалгалт хийгээд, гэмт хэргийн зөрчилтэй байж болзошгүй мэдээллүүдийг гаргаад тэрийгээ татварын алба маань өөрөө баталгаажуулсны үндсэн дээр хууль хүчний байгууллага руу хүргүүлж байгаа. Хууль хүчний байгууллагууд өөрөө тэр мэдээлэл дээр үндэслээд тэр нь өөрөө гэмт хэргийн зөрчилтэй юм уу, эс үгүй бол хуурамч бичиг баримт бүрдүүлсэн байна уу гэдгийг нь тогтоох юм болбол тэр нь цаашаагаа хууль хүчний байгууллага нь өөрөө эрүүгийн хуулийнхаа асуудлаар явж байгаа.

За татварын 2 дахь асуудлын хувьд татварын байгууллага дээр өр болбол ерөнхийдөө байгаа. Одоогийн байдлаар хуримтлагдсан өрийн үлдэгдэл 3.9 их наяд төгрөгийн өр байна. Татварын байгууллага өөрийнхөө үндсэн чиг үүргийнхээ хүрээнд төсвийн орлогыг бүрдүүлэх үндсэн чиг үүргийнхээ хүрээнд татвар, өртэй татвар төлөгчдөө бол өр хураах ажиллагааг хэрэгжүүлж байгаа юм. Гэхдээ хэрэгжүүлэхдээ болбол татвар төлөгчийн өртэй компаниудыг бүгдийг энэ дээр нь данс хаах ажиллагааг хийхээсээ урьдаж, татвар төлөгчдөд зөвлөгөө, арга зүйгээр хангаад...

Д.Жаргалсайхан: Хариултыг гүйцээж хариулъя. 6 номер.

Р.Мягмаржав: Татвар төлөөгүйгээс үүсэх эрсдэлийг нь болбол сануулж байгаа юм. 2 дугаарт татвар төлөгчдөд татвараа төлөхтэй холбоотойгоор татварын албанаас болбол нэхэмжлэх хуудсыг хүргүүлж байгаа юм. Нэхэмжлэх хуудсан дээрээ тухайн татварын өрийг хэзээ төлөх вэ гэдэг нь хугацаа заачихсан. Ихэвчлэн бол 10 хоногийн дотор хугацаагаа татвараа төлөөрэй гэсэн санамжийг болбол өгч байгаа. Үүнийхээ дараа татвар төлөгч маань төлөөгүй тохиолдолд татвар төлөгчид нь мэдэгдэж байж дансыг нь хаах ажиллагаа бол хийгээд явж байгаа. Гэхдээ энэ жилийн хувьд болбол тайлант оны ноогдол буюу 2024, 2025 оны ноогдол дээр болбол үр хураах ажиллагаа хэрэгжүүлэхгүй буюу 2024 оноос өмнөх өр дээр болбол тэр нь үр хураах ажиллагааг хэрэгжүүлээд явж байгаа.

Д.Жаргалсайхан: Пүрэвдаваа гишүүн тодруулна.

Д.Пүрэвдаваа: За ийм байна аа. 1 их наяд төгрөгийн найдваргүй татварын авлага байна аа гэж бичигдсэн байна энэ. Та бүхний тарааж өгсөн зүйл дээр.

Дээрээс нь 7 их наядын тийм гэмт хэргийн шинжтэй үйлдэл байна. Татварын нийт өр чинь бол 3 их наяд юм байна шүү дээ. Тэгээд та нар яагаад тэгээд ингээд төсвөө нэмнэ гэж орж ирээд байсан юм 2024 онд. Энэ чинь нэг л уялдахгүй харагдахгүй байна. Энэ чинь татварын байгууллага чинь татвар төлөх боломжтой эх үүсвэрүүдээ тооцож, төсвөө нэмдэг биз дээ. За тайлбар авъя.

Д.Жаргалсайхан: 6 номер.

Р.Мягмаржав: Нэмэлт тайлбар өгье. Саяын 3.9 их наяд төгрөгийн өр гэдэг болбол өөрөө татварын албанд хуримтлагдсан өрийн үлдэгдэл. Тайлант жилийн хугацаанд буюу 2024 оны жилийн эцэс болон 2025 онд татвар төлөгчийн өгч байгаа тайлангаараа болбол одоогийн байдлаар 4 их наяд төгрөгийн ноогдол болбол байгаа юм. Ноогдлын дутуу үлдэгдэл. Энэ маань өөрөө жилдээ барагдаад явдаг өр байгаа.

Татварын байгууллагаас яг өр хураах үйл ажиллагаа маань яг саяын миний хэлсэн 3.9 их наяд төгрөгийн өр дээрээ өр хураах ажиллагааг хэрэгжүүлээд явж байгаа. Тэгэхлээр ингээд үзэх юм болбол ойролцоогоор болбол нэг 8 орчим их наяд төгрөгийн манайх бол татварын байгууллага одоо төсөвтөө хурааж төвлөрүүлнэ ээ гэсэн ийм тооцоолол байна гэсэн үг.

Д.Жаргалсайхан: За баярлалаа. Ингээд гишүүд асуулт асууж, хариулт авлаа. За хэлэлцэж байгаа асуулттай холбоотой санал хэлэх гишүүд байна уу? үг хэлэх гишүүд байна уу? Нэрээ өгье. Нэг гишүүн байна. Пүрэвдаваа гишүүн үг хэлнэ ээ.

Д.Пүрэвдаваа: Энэ Эдийн засаг, хөгжлийн яамныхан байна уу? Тэр нөгөө Төрийн нарийн бичгийн дарга өнгөрсөн жил орж ирсэн. Тэр Батхүү нь байна уу? Эдийн засгийн хөгжлийн яамнаас хүн байхгүй байгаа юу. Ингэсэн юмаа. Одоо Учрал гишүүн бол сая нөгөө Эдийн засгийн сайд болсон учраас өнгөрсөн 2024 оны асуудал чинь бол эдийн засагчид ялангуяа төсвийн тогтвортой байдлын зөвлөл сануулаад хэлсэн байхгүй юу. Энэ тоонууд чинь зөрөөд байна аа, манай тоог ашиглаач ээ. Эдийн засаг чинь ингэж өсөхгүй ээ. Эрсдэлтэй нөхцөл байдал үүснэ ээ гээд гэхэд Эдийн засаг, хөгжлийн яам энэ дээр ямар ч эрсдэл байхгүй ээ, 27 их наяд байсан төсвийг 30 болгож нэмэгдүүлнэ ээ гээд тэгээд тодотгосон. 8 сард 2024 оны. Оны эцэст гэхэд байгууллагууд нь мөнгөө үрж чадахгүй, дансан дахь мөнгөнүүд нь бүүр хэтэрчихсэн ийм нөхцөл байдалтай байсан.

Тэгээд одоо аудитын дүгнэлтийнх нь нөхцөл байдлыг хар даа. 7 их наядын зөрчил гэдэг бол маш их зөрчил шүү. Тэгээд би энэ зузаан материал байсан учраас сая Баасан гарагт бол уншиж амжаагүй байсан. Сая 131 дүгээр хуудсан дээр аудитын байгууллага дүгнээд ороод ирчихсэн байна. Нийт төсвийн орлогын 26 хувь гэдэг бол энэ онцгой тоо шүү. Тэгээд энэ дээрээ та бүхэн маань тэр дотоод хяналт байдаг юм уу, за тэгээд Эрүүгийн хууль, Татварын тухай хууль, Хэмнэлтийн тухай

хууль маш олон хууль тогтоомж зөрчсөн энэ бол эрүүгийн шинжтэй гэмт үйлдэл шүү гэдгийг хэлмээр байна аа. За баярлалаа.

Д.Жаргалсайхан: Гишүүд үг хэлж дууслаа. Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгдсэн тайлан болон Монгол Улсын 2024 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцсэн талаарх Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд Улсын Их Хурлын гишүүн Ганбатын Очирбат гишүүн танилцуулна аа.

12:23

Д.Жаргалсайхан: Ингээд дараагийн хэлэлцэх асуудалдаа оръё.

Хэлэлцэх асуудал 2. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, ЭМД-ын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дахь хэлэлцүүлгийг л эхэлье ээ.

Ингээд Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, ЭМД-ын сангийн 2025 оны өөрчлөлт оруулах тухай танилцуулгыг Сангийн сайд Болдын Жавхлан танилцуулна аа.

Б.Жавхлан: Эрхэм байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Дэлхий дахинд үүсээд буй сорилт бэрхшээлийн Монгол Улсын эдийн засаг, нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, мөн Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд өөрчлөлт оруулсантай холбоотойгоор Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.2, 34.1.4 дэх заалтын дагуу Монгол Улсын 2025 оны төсвийн тодотголын төслийг боловсруулж, 2025 оны 6 дугаар сарын 25-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн.

Эдийн засгийн сорилт хүндрэлийг даван туулахад төсвийн сахилга бат, үр ашигтай зарцуулалт онцгой чухал үүрэгтэй. Тиймээс хэмнэлтийн тодотголд бүх шатны төрийн байгууллагуудын тэвчиж болох зардлыг хэмнэх зарчмыг баримталлаа. Цомхон бүтээмжтэй төртэй байхын тулд төрийн албаны орон тоог 2026 оны хөгжлийн төлөвлөгөөнд нийцүүлэн 9 хувиар бууруулахаар тооцлоо. Мөн төсвийн байгууллагын тээвэр шатахуун, дотоод албан томилолт, хичээл, үйлдвэрлэлийн зардал, төрийн өндөр дээд айлчлал болон өндөр түвшний зочин төлөөлөгчид хүлээн авахаас бусад гадаад том албан томилолт, зочин төлөөлөгч хүлээн авах зардал, тавилга эд хогшил худалдан авах, урсгал засвар хийх болон багаж техникийн зардал төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудад олгодог татаасны зардал, байгууллагаас олгох нэг удаагийн болон бусад төрлийн тэтгэмж, урамшуулал, хөтөлбөр, арга хэмжээний зардал зэргийг хэмнэхээр тооцож холбогдох өөрчлөлтийг тодотгохыг төсөлд тусгалаа.

Энэ хүрээнд Зам, тээврийн сайдын багцын төсөв 2025 оны батлагдсан төсвөөс урсгаж зардал 1.5 тэрбум төгрөгөөр, хөрөнгийн зардал 76 тэрбум төгрөгөөр

нийт 77.5 тэрбум төгрөгөөр бууруулахаар төлөвлөсөн болно. Тус салбарын төрийн албан хаагчийн тоог 9 хувиар буюу 26 орон тоогоор бууруулж, 256 орон тоотой байхаар тооцлоо. Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын багцын төсөв 2025 оны батлагдсан төсвөөс урсгал зардал 2.2 тэрбум төгрөгөөр, хөрөнгийн зардал 21.1 тэрбум төгрөгөөр нийт 23.3 тэрбум төгрөгөөр бууруулахаар төлөвлөсөн. Тус салбарын төрийн албан хаагчийн тоог 9 хувиар буюу 9 орон тоогоор бууруулж, 122 орон тоотой байхаар тооцлоо.

Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын багцын төсвийг 2025 оны батлагдсан төсвөөс урсгал зардал 1.7 тэрбум төгрөгөөр, хөрөнгийн зардал 0.2 тэрбум төгрөгөөр нийт 1.9 тэрбум төгрөгөөр бууруулахаар төлөвлөсөн болно. Тус салбарын төрийн албан хаагчийн тоог 9 хувиар буюу 33 орон тоогоор бууруулж, 232 орон тоотой байхаар тооцлоо. Эрчим хүчний сайдын багцаас төрийн албан хаагчдын орон тоог 9 хувь буюу 10 орон тоогоор бууруулж, 100 орон тоотой байхаар тооцсон.

Дээрх хэмнэлтийн бодлогын хүрээнд эрчим хүчний багцаас 739.6 сая төгрөг буурахаар төлөвлөлөө. Харин ДЦС 3 ТӨХК-ийн өндөр даралтын турбин цехийн барилга байгууламжид гарсан гэнэтийн аваар осол, гал гарч томоохон эрсдэл үүссэнтэй холбогдуулан гамшиг ослын хохирол, хор уршгийг бууруулах, өвлийн их ачаалалд дулаанжуулалтын тоноглолын бэлэн байдлыг хангах зайлшгүй шаардлагын хүрээнд 35.5 тэрбум төгрөг, дулааны станцууд болон эрчим хүчний компаниудын найдвартай ажиллагааг хангах зорилгоор 9.1 тэрбум төгрөгийг эрчим хүчний шөнийн тарифын хөнгөлөлтийн хугацааг уртасгасантай холбоотой 26 тэрбум төгрөгийг тус тус нэмж тусгасан.

Хөдөө аж ахуйн салбарын 2025 оны батлагдсан нийт төсөв 723 тэрбум төгрөгөөс дол 676.7 тэрбум төгрөг болж, хөрөнгийн зардлаас 2.3 тэрбум төгрөг, урсгал зардлаас 44 төгрөг хасагдаж нийт 46.3 тэрбум төгрөг буюу 7 хувь буурсан байна аа.

Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөнд туссан төрийн албаны реформын шинэчлэлийн хүрээнд багш, эмчээс бусад төрийн албан хаагчдын орон тоог 9 хувиар бууруулахаар төлөвлөсний дагуу салбарын хэмжээнд нийт 2117 орон тоо батлагдсанаас 187 орон тоог бууруулахаар төлөвлөлөө. За ийнхүү 2025 онд төсөвт тодотгол хийснээр нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогыг 3 их наяд 260 тэрбум төгрөгөөр бууруулж 30 их наяд 209 тэрбум төгрөг, нэгдсэн төсвийн нийт зарлагын хэмжээг 1 их наяд 856 тэрбум төгрөгөөр бууруулж, 31 их наяд 575.1 тэрбум төгрөгт хүргэж, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 1 их наяд 365.2 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 1.5 хувийн алдагдалтай болж байна аа.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, ЭМД-ын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон дагалдах хууль, тогтоомжийн төслүүдийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Жаргалсайхан: Сангийн сайдад баярлалаа. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, ЭМД-ын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд хийсэн аудитын дүгнэлтийн талаарх танилцуулгыг Монгол Улсын Ерөнхий аудитор Сандагийн Магнайсүрэн танилцуулна аа.

С.Магнайсүрэн: Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Төрийн аудитын байгууллага Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль, Төрийн аудитын тухай хуульд тус тус заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 6 сарын 25-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд дүгнэлт өгөх аудитыг хийж гүйцэтгэлээ.

2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл тус Байнгын хороонд хамаарах 5 төсвийн ерөнхийлөн захирагчийн төсөвт төвлөрүүлэх орлогыг нийт 98.5 тэрбум төгрөгөөр, зарлагыг 77 тэрбум төгрөгөөр тус тус бууруулахаар төлөвлөжээ.

Байнгын хороо энэхүү төслийг хэлэлцэн шийдвэрлэхдээ дараах асуудалд анхаарал хандуулахыг санал болгож байна. Үүнд уул уурхайн салбарын орлого гадаад зах зээлийн нөхцөл байдлаас хамаарч тодорхой бус эрсдэлтэй байгаа учир уул уурхайн бус орлогын боломжит эх үүсвэрийг бүрэн дайчлах, татварын хуримтлагдсан өр төлбөрийг барагдуулах, хураалт үйлчилгээг сайжруулах. Төрийн албан хаагчдын тоог чиг үүргийн давхардал, ажлын байрны ачаалалд бүрэн шинжилгээ хийлгүйгээр нийгэм, эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулан төсвийн ерөнхийлөн захирагчдын орон тоог жилд 9 хувиар бууруулахаар тооцсон нь төрийн үйлчилгээний чанар хүртээмжид нөлөөлж болзошгүй.

Иймд төсвийн ерөнхийлөн захирагчдад өөрийн хариуцсан салбартаа чиг үүргийн шинжилгээ ажлын байрны ба бүтээмжийн үнэлгээг хийсний үндсэн дээр ажлын ачааллыг оновчтой хуваарилах зорилгоор харьяа байгууллагуудынхаа сул орон тоонд зохицуулалт хийх боломж олгох асуудлыг судалж үзэх.

3-т нь төсвийн тодотголын хамт Улсын Их Хуралд өргөн барьсан тогтоолын төсөлд 2025, 2026 оны төсвийн жилд өндөр насны тэтгэвэр тогтоолгох болон хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар чөлөөлөгдсөн орон тоонд нөхөн томилгоо хийхгүй байх, шинээр ажлын чиг үүрэг, албан тушаалын орон тоог бий болгохгүй байх, ажлын байрны ачааллыг нягтруулах зэргээр цалин хөлсний зардлыг хэмнэх гэж заасан. Энэ нь чиг үүргийн судалгаа хийсний үндсэн дээр ажлын ачааллыг нягтруулж, орон тоогоо зорилтот түвшнийг хүртэл нэгэнт бууруулсан байгууллагуудад сул орон тоонд нөхөн томилгоо хийхгүй байх нь төрийн тухайн байгууллагын хэвийн үйл ажиллагаа алдагдах үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхэд сөргөөр нөлөөлж болзошгүй эрсдэл байгааг анхаарч үзэх.

4-т нь төсвийн ерөнхийлөн захирагч нарын сул орон тоо, харьяа сул орон тооноос бусад цомхотголд орж буй албан хаагчид Төрийн албаны тухай хуульд

заасны дагуу ажлаас чөлөөлөгдсөний нэг удаагийн тэтгэмжийн зардал шаардагдахаар байгааг энэ хуулийн төслийн хэлэлцүүлгийн явцад хамтад нь шийдвэрлэх гарц шийдлийг олох.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 23 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан гэж дүгнэснээ үүгээр танилцуулж байна.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Жаргалсайхан: Монгол Улсын Ерөнхий аудиторт баярлалаа. Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийн талаарх товч танилцуулгыг Улсын Их Хурлын Тамгын газрын Төсвийн хяналт шинжилгээний хэлтсээс бэлтгэн ирүүлснийг та бүхэнд хүргүүлсэн болно.

Ингээд хуулийн төслүүдийн талаарх Сангийн сайдын танилцуулга болон аудитын дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Очирбат гишүүн, Жангабыл гишүүн байна. За ингээд Очирбат гишүүнийг асуултаа асуухыг хүсэж байна аа.

Г.Очирбат: Үндэсний аудитын газрын энэ дүгнэлттэй холбоотой л би даргаас бас асуулт яах вэ зөвлөмж өгч байгааг нь ойлгож байгаа юм. Тэгэхдээ энэ чинь судалгаа гарчхаад байна шүү дээ. Энэ чинь 20 орчим хувийн ажил, албан тушаалын чиг үүргийн давхцал байна аа гээд Учрал сайд хэлсэн шүү дээ. Дээрээс нь Эдийн засгийн хөгжлийн яамны сайд Гантөмөр сайд байхдаа чиг үүргийн шинжилгээ хийгээд 9 хувиар бол цомхотгох бололцоотой байна гэж байгаа юм. За энэнтэй уялдуулаад Сангийн яамнаас Төрийн албан хаагчийн тухай хуулийг МАН-ын бүлгээр оруулаад танилцуулсан. Тэгээд бүлэг дээрээ бөөрөлхөөд асуудлыг шийдэхгүй, гол цөм рүү нь орохгүйгээр энэ хуулийн төслийг нь унагаагаад байгаа байхгүй юу. Тэгээд би бас түрүүн хэллээ шүү дээ.

Чиг үүргийн давхцалуудыг алга болгохгүй бол салбар болгон өөрөө өөрийнхөөрөө дураараа энэ хуулийг батлуулчихсан сүүлийн 8 жил. Тэгээд энэ дээрээ дураараа дургиж, дунд чөмгөөрөө наадаад байгаа байхгүй юу даа. Тэгээд манай аудитынхан энэ тайлангаа, зөвлөмжөө өгөхдөө бас их зөв өгөх хэрэгтэй шүү. Тэгээд энэ Зүүн Азийн орнуудыг судал. Мянган хүнд хэдэн төрийн албан хаагч үйлчлээд байгаа юм. Яагаад энэ сүүлийн үед биг дата гэж яриад л, Эй Ай технологи оруулж ирээд байгаа юм. Бүх юмыг хүнээс хамааралгүй л болгож байгаа шүү дээ. Хүн хийгээд ирэхээрээ л цаана нь авлига л байгаа шүү дээ. Хүн гарын үсэг зураад ирэхээрээ л хүнд суртал байгаа. Тэгээд энэ чиглэл рүү нь манай аудитынхан маань цаашаа шахаж ажиллаасай гэж хүсэж байгаа. Наранчимэг дарга аа. Тэгээд та хэд маань энэ рүүгээ шахахгүй, зөвлөмжөө өгөхдөө хүртэл тэр одоо бараг болохгүй байна гэдэг чиглэлээ өгөөд байх юм бол бас утгагүй юм болно шүү. Хаа хаанаа зарчим дээрээ байх хэрэгтэй. Болохгүй байна, орлого тасарч байна, зарлага нэмэгдээд байдаг. Зарлага хаана нэмэгдээд байгаа юм. Урсгал зардлууд дээр л асар их хэмжээгээр янз бүрийн нэр томьёоллуудыг нь өөрчлөөд орж ирж нэмэгдээд байгаа биз дээ. Тэгээд тэр урсгал зардлаа л эхнээс нь зоригтойгоор хэдүүлээ багасгая л даа. Тэгээд энэ зарчим дээрээ л байцгаая л даа. Тэгээд дэлхийн

хөгжлийнхөө чиг хандлагыг дагаад л явъя л даа. Заавал Монгол Улс гэхээрээ бүх юмыг хүн хийж байх ёстой юм уу. Тийм юм байхгүй шүү дээ.

Тэгээд чиг үүргийн давхцалыг тэр Матр шинжилгээ хийж үзэх хэрэгтэй шүү дээ. Албан тушаал болгон дээр. Тэгж байж бас зөвлөмжөө бас их зөв өгөөрэй л гэж хүсье дээ аудитынханд. Өчигдрөөс хойш 2, 3 Байнгын хороон дээр ингэж яриад байгаа. За яах вэ, дүгнэлтээ, зөвлөмжөө ингээд биччихсэн болохоор биччихсэн зөвлөмжийг уншдаг л байх. Тэгээд хойшдынхоо юман дээр анхаарах хэрэгтэй шүү л гэж хүсье.

Д.Жаргалсайхан: Учрал сайд хариулъя.

Н.Учрал: Тийм. Энэ Очирбат гишүүн яг ийм цаг үеэ олсон асуудлыг хөндөөд байгаа юмаа. Энэ төрийн албан дээр чиг үүргийн шинжилгээг хийгээд, тухайн үед Гантөмөр сайдын үед улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө дээр 2026 онд төрийн албан хаагчдын 9 хувь цомхотгоно гэдэг ийм зорилтыг оруулсан. Энэ болбол өөрөө зүгээр нэг тийм 9 гээд тавьчихсан тоо бол биш юм байна лээ. Энэ дээр болбол ийм чиг үүргийн шинжилгээ хийгээд үүндээ үндэслээд 2026 онд энийг хийнэ ээ гэдэг зорьсон. Гэхдээ 2026 оны жилийн төлөвлөгөөнд туссан энэ зорилтыг сая төсвийн хүрээнд төсвийн тодотголыг барихдаа хэрэгжүүлээд эхэлье ээ гэдэг зорилтын дагуу Засгийн газраас өргөн мэдүүлсэн хууль нь тэр төрийн албаны хууль дагалдсан. Гэхдээ одоо тэр 14400 төрийн албан хаагч гэдэг тоо болбол зүгээр гаргаад ирчихсэн тоо болбол биш. Энэний 6 мянган албан хаагч бол бараг сул орон тоо.

Нөгөө үлдсэн төрийн албан хаагчдын тоо болбол юу вэ гэхээр хэн нэгнийг ажилгүй болгох гээд байгаадаа биш ээ. Нэг ажлыг одоо 3 хүн хувааж хийгээд байгаа буюу хэрвээ бүтцийн өөрчлөлт хийгдээд, чиг үүргийн хувьд түүний эрхэлж байсан асуудал өөр одоо албан хаагч руу шилжсэн байгаа тохиолдолд өөр бүтэцтэй нэгдсэн байгаа тохиолдолд одоо тухайн төрийн албан хаагч болбол хуулийнхаа дагуу ажлаас чөлөөлөгдөх ийм асуудлыг яригддаг. Гэхдээ бид нар одоо юу гэдэг юм. Төрийн албан хаагчдыг цомхотголоо гээд шууд одоо ажлаас чөлөөлнө гэхээсээ илүү жишээ нь энэ чинь бүтцийн хүрээнд шилжилтүүдийг хийнэ. Дээрээс нь энэ чинь хэрвээ гэнэт одоо төрийн албанаас чөлөөлөгдөх юм болбол нөгөө тэтгэмжийн зардал нь бараг 200 тэрбум төгрөг дөхөх байхгүй юу.

Тэгэхээр бид нар юу вэ гэхээр нөгөө хүний тоо ярьж, хүн ярихаасаа илүүтэйгээр зүгээр чиг үүргийн шинжилгээ хийх боломжтой. Тийм учраас жилийн төлөвлөгөө нэгэнт Их Хурлаар баталчихсан бол үүндээ бид нар хариуцлагадаа эзэн болох ёстой. Өнөөдөр одоо бараг энэ тоонуудыг харахаар чинь 2012 онд 162769 төрийн албан хаагч байсан чинь 2024 онд 226895 болчихоод байна шүү дээ. Гэхдээ энэний төрийн захиргааны албан хаагчдын тоо үүнийг дагаад өсөхгүй байгаа юм. Их сонин. Тэр нь юу вэ гэхээр тэр үндэсний хороо, зөвлөл 28 ажлын алба буухад 311 тэрбум хэмнэчихэж байгаа байхгүй юу. Нэг ёсондоо төрийн жинхэнэ албан хаагчдын тоо нь төдийлөн нэмэгдэхгүй байгаа мөртөө нөгөө ТҮ-нүүд, тэгээд нөгөө статус нь тодорхойгүй нөгөө баахан үндэсний хороо, зөвлөл, комисс одоо юу байдаг юм ингээд нэмэгдээд яваад байдаг.

Тэгэхээр байгаа төрийн төрд тангаргаа өргөсөн төрийн жинхэнэ албан хаагчдын цалин хөлс, нийгмийн баталгаа нь хангалттай байгаад түүний одоо статусын хэмжээнд бусад одоо төрийн албан хаагчдын тоог ахиулахгүй байх бодлого барих ёстой. Дээрээс нь одоо жишээ нь 360 зөвшөөрөл зөвшөөрлийн

хуулиар байгаа шүү дээ. Энгийн зөвшөөрлийг л мэргэжлийн холбоонд шилжүүлэхэд энэ төрийн албан дээр бараг нэг 4 мянга орчим хэмнэгдэж байгаа байхгүй юу.

Нөгөө зөвшөөрөл олгож байгаа үйл явцыг чинь л нэг 5 нөхөр хийгээд байна шүү дээ. Хуучин энэ хуульчдын сонгон шалгаруулалт аваад л, хуульчдын гэрчилгээ өгөөд л энэ ажлыг хэдэн хүн хийдэг байсан юм. Хууль зүйн яаманд нэг 6, 7 хүн л нэг газар болоод л хийдэг байсан шүү дээ. Түүний дараа Хуульчдын холбоо энэ ажлаа авсны дараа дотроо хурал зөвлөгөөнөө хийгээд л, дарга цэргээ сонгоод л өөрсдөө өөрийгөө санхүүжүүлээд л явж байгаа шүү дээ.

Тэрэн шиг Барилгын хөгжлийн ассоциаци ч гэсэн ингээд л Барилга хөгжлийн төвийн ажлыг хийж болно шүү дээ. Тэнд заавал хэдэн хүн авч явах ямар шаардлагатай байна. Тэгэхээр энэ төрд байгаа энэ олон улсын төсөвт үйлдвэрийн газар, энэ төрийн зарим чиг үүргийг хэрэгжүүлэх хувийн хэвшил хийх бололцоотой асуудлыг хумихад болбол бүрэн боломж байгаа. Тийм учраас нэгэнт батлагдсан жилийн төлөвлөгөөгөө хэрэгжүүлж ажиллах нь одоо Засгийн газрын үүрэг учраас энэ одоо хуулийг өргөн мэдүүлсэн. Тэгэхээр цаашдаа болбол бид нар энэ жилийнхээ төлөвлөгөөнд эзэн болж ажиллана аа л гэж хэлье.

Д.Жаргалсайхан: За баярлалаа. Очирбат гишүүн тодруулга.

Г.Очирбат: Учрал сайдад бас зарчим дээрээ байгаад нь талархаж байна. Учрал сайд Цахим хөгжлийн яамны сайд байсан. Хэрэг эрхлэх газрын дарга байсан. Одоо Тэргүүн Шадар сайд. Биг дата, И монголиа нэвтрүүлэлтийн үндсэн концепц суурийг нь ойлгож мэдэрдэг, мэдэрч одоо тэрийг эхлүүлсэн гэж ойлгож байгаа. Тэгэхээр цаашдын төрийн үйлчилгээгээ ер нь төрийн хүнд суртлыг байхгүй болгохын тулд таны тэр цахим хөгжил дээрээс эхлүүлсэн ажлын чинь манлайлал их хэрэг болох ёстой шүү. Та тэрийгээ бас мартаж болохгүй.

Бид төрийн албан хаагчийг нэмэгдүүлнэ гэхээсээ илүүтэйгээр технологийнхоо давуу талыг ашиглаж, хиймэл оюун ухаан Эй Ай-гаар шийдвэр гаргуулъя аа. Тэнд хүнд суртлыг байхгүй болгоё, зөвшөөрөл өгдөг дарга нарыг байхгүй болгоё. 200 мянган төрийн албан хаагчийн чинь 20 мянга нь дарга шүү дээ Учрал сайд аа. Хэлтсийн дарга, тасгийн дарга, одоо ажлын хэсгийн дарга ингээд дандаа дарга нар. Тэгээд энэ дээрээ анхаарч ажиллаарай гэж хүсье.

Д.Жаргалсайхан: 3 номер Наранчимэг Ерөнхий аудиторын газар.

Ц.Наранчимэг: Очирбат гишүүний асуултад тайлбар тодруулга хийе гэж бодож байна. Төрийн аудитын байгууллага аудит хийгээд дүгнэлтээ гаргахдаа аливаа нотлох баримтад үндэслэхгүйгээр дүгнэлтийг гаргадаггүй. Энүүгээрээ бас аудитын байгууллага өөрсдөө хариуцлага хүлээх ийм стандарттай ийм байгууллага байгаад байгаа. 1 дүгээрт манайх зөвлөмж өгөөгүй. Төсвийн тодотголд бол зөвлөмж өгдөггүй. Бид нар дүгнэлт гаргаж байгаа. Яагаад 9 хувийг хасахыг аудитын байгууллага одоо дэмжээгүй биш дэмжиж байгаа.

Гэхдээ салбар бүрээс жигд хасаж байгаа нь ажлын ачаалалтай нь дүн шинжилгээ хийхгүйгээр механикаар хассан байна аа гэдгийг бид нар яагаад ийм дүгнэлт өгсөн гэхээр Төрийн аудитын байгууллагаас Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооноос баталж өгсөн сэдвийн хүрээнд төрийн байгууллагын хүний

нөөцийн бодлого, тогтолцооны үр нөлөө гэсэн гүйцэтгэлийн аудитыг хийсэн. Энэ аудитаар одоо ажил, ажлынхаа одоо шинжилгээ хийсэн давхардлаа тооцсон нэг ч...

Д.Жаргалсайхан: Хариултыг нь бүрэн хариулт авъя. 3 номер.

Ц.Наранчимэг: Шинжилгээ хийсэн байгууллага байгаагүй. Тийм учраас ганцхан Боловсролын яам байсан. Тийм учраас шинжилгээ хийгээгүй, үр дүнг нь тооцоогүй ямар байгууллагаас, ямар хүний одоо 9 хувиар бууруулах юм бэ гэдгийг жигд хуваарилсан дээр аудитын байгууллага ингэж болохгүй ээ гэсэн ийм дүгнэлтийг болбол гаргаж байгаа 1 дүгээрт.

2 дугаарт нь энэ чиг үүргийн шинжилгээнийхээ хийсэн нотлох баримтыг төсвийн тодотгол дүгнэлт хийхэд бид нарт ирүүлээгүй. Аудитын байгууллага ирүүлсэн нотлох баримтын хүрээнд аудит хийж дүгнэлтээ гаргадаг. Тийм учраас бид нар энийг энэ гүйцэтгэлийн аудитаар илэрсэн энэ зөрчлүүд хэвээрээ байгаа юм байна аа гэж үзээд энийг одоо төсвийн бүх сайд нараас бүх одоо төсвийн ерөнхийлөн захирагчаас жигд хасаж байгаа нь бол буруу байна. Энэ дээр дүн шинжилгээ хийж үзэх ёстой гэсэн ийм дүгнэлтийг гаргаж, энэ дүгнэлтээ танилцуулж байгаа юм.

Д.Жаргалсайхан: За тодруулга бас Учрал сайд хийх юм байна. Учрал сайдын микрофон.

Н.Учрал: Тэгээд би энэ Үндэсний аудитын газрын зөвлөмжийг болбол одоо хүлээж авч байгаа юм. Ер нь болбол төрийн албан хаагчдыг 9 хувь хэмнэнэ ээ гээд ингэж хавтгайруулж 9 хувь хэмнэнэ гэж байхгүй ээ. Жилийн төлөвлөгөөн дээр тусгагдаад ингээд орхичихсон байгаа болохоос биш энэ чинь өөрөө төрийн бүтээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр процессын дахин инженерчлэлийг үр дүнтэй хэрэгжүүлээд, төрийн үйлчилгээний хурд, чанарыг сайжруулж, үр ашиггүй давхардсан үйлчилгээг халж, цахим шийдлийг нэвтрүүлэх замаар зардлыг бууруулж, зорилтот хүн хуулийн этгээдэд проактив хэлбэрээр хүргэхээр дахин инженерчилнэ гэдэг ийм жилийн төлөвлөгөөний зорилттой байхгүй юу.

Тийм учраас 9 хувь гэж ингээд бүгдэд нь хавтгай нэмэх бол буруу. Тийм учраас энэ дээр Ре-инженеринг хийнэ ээ гэж ярьдаг. Тэгэхээр энийг бол бодит утгаар нь хийнэ. Тийм учраас сая Их Хурлаас баталсан хуулиар энэ төрийн бүтээмж, нээлттэй засгийн түншлэл Эдийн засаг, хөгжлийн сайд дээр ирсэн. Тэгэхээр энэ ажил руу бас их өгөгдөл дээр суурилсан ажлаа үргэлжлүүлнэ ээ л гэж хэлье.

Д.Жаргалсайхан: За баярлалаа. Ингээд Жангабыл гишүүн асуулт асууна.

Х.Жангабыл: Та бүхэнд өдрийн мэндийг хүргэе ээ. Би Сангийн сайдаас асуулт байна аа. Бид төсвөө тодотгож байна. Зардлыг болбол тултал нь бууруулсан байгаа. Гэхдээ сайд хэд хоногийн өмнө сэтгүүлчдэд ярилцлага өгөхдөө нэг 2, 3 асуудлыг эрэмбэлж ярьсан юмаа.

1 дүгээрт энэ ТЭЦ 3 дулаан станцын одоо сэргээн засварлах асуудлыг болбол эхний ээлжид танаж болохооргүй. Одоо төсвийг нь заавал тавьж өгөх хэрэгтэй гээд хэлчихсэн байгаа.

2 дугаарт энэ Ойрх Дорнодтой холбоотой, сүүлийн үед бол дэлхийн энэ геополитикийн нөхцөл байдал хүндэрч байгаатай холбоотой. Газрын тосны одоо нөөц бүрдүүлэх, дээрээс нь одоо санхүүжилтийг одоо нөөц бүрдүүлэхэд шаардлагатай санхүүжилтийг нь шийдэх асуудлыг та бас ярьж байсан. Энэ сар гэхэд чинь бараг л ОХУ-ын хил үнэ сая 60 доллароор нэмэгдлээ 7 сард. Бид болбол урьдчилан тааварлаж болзошгүй тийм нөхцөл байдал үүсэж байна. Тэгэхээр нөөц бүрдүүлэх нь зүйтэй. Тэгэхээр энэ төсвийн тодотгол дээр та энэ төсвийн санхүүжилт тавьж өгсөн үү? Эндээс хараад олохгүй байна аа. Тавьж өгөөгүй бол ерөөсөө л тавьж өгөх үү? ямар зарчим баримталж байна, ямар механизмаар энэ нөөц бүрдүүлэх юм бэ гэсэн асуулт байна даа.

Д.Жаргалсайхан: Сангийн сайд хариулах уу? Жавхлан сайдын микрофон.

Б.Жавхлан: Жангабыл гишүүний асуултад хариулъя. Энэ удаагийн тодотгол маань ер нь хэмнэлтийн тодотгол, хэмнэлтийн тодотгол. Зардал нэмэгдэж байгаа гурван л асуудал байгаа.

1 дүгээрт саяын таны дурдсан энэ ТЭЦ 3 дээр гарсан осол. Бид өвөл удахгүй болно. Бид нар бэлдэх ёстой. Тэнд гал алдаж болохгүй. Дээрээс нь энэ ТЭЦ 3-ын ослоос гадна энэ жил бид нар дулааны тарифаа нэмнэ гэж тооцоолж, 2024 онд 2025 оныхоо төсвийг хийсэн юм. Гэтэл дулааны тарифаа нэмэх асуудал маань хойшлогдсон учраас үлдсэн хагас жилд дулааны зардал төсвийн байгууллагууд дээр нэмэгдэнэ. Энийг тавихгүй болбол цаанаа нөгөө дулааны энэ ТЭЦ-үүд маань орлого байхгүй бүүр баларна. Тийм учраас ийм холбоотой эрчим хүчний салбар дээр зардал нэмэгдэж байгаа.

Шатахууны нөөц бүрдүүлэх асуудал одоогоор хариуцсан яамнаас ийм санал ирээгүй байгаа. Тодорхой ямар ч асуудал тавигдаагүй. Тийм учраас төсөв дээр бол тусгагдаагүй тийм. Энэ удаагийн хэмнэлтийн төсөв учраас нэмэгдэх асуудал дээр зарчмын хувьд эрэмбэлэгдсэн 3 асуудал бол нэмэгдсэн. 4 дэх асуудал болж энэ одоо асуудал ерөөсөө огт одоо яамнаас ийм асуудал ирээгүй ээ. Тийм учраас байхгүй.

Д.Жаргалсайхан: Жангабыл гишүүн тодруулга.

Х.Жангабыл: За зөвлөмж юм уу даа. Би тодорхой юм хэлье ээ. Сая Учрал сайд Евроазийн худалдааны түр хэлэлцээрт гарын үсэг зурсан. Энэ хэлэлцээрийн үр дүнд манай шатахууны одоо гаалийн татвар 5 хувиар хямдарна аа. Энэ 5 хувийг та онцгой татвар байдалдаа одоо тавьж өгөөд, эндээс гарч ирсэн одоо хэмнэсэн мөнгөөрөө нөөц бүрдүүлэх асуудлыг яривал, хийвэл яасан бэ гэсэн зөвлөмж маягийн юм танд одоо хэлэхээр байна аа. Одоо жишээлэхэд жилд сая 600 тонн дизель түлш импортолдог, импортоор авдаг. Тэрний хэмнэж байгаа нэг тонныг нь 150 мянган төгрөгөөр онцгой татвар тавивал 240 тэрбум төгрөгийн эх үүсвэр бий болох, бий болж болно. Энэ 240 тэрбум төгрөг...

Д.Жаргалсайхан: Сангийн сайд Жавхлан сайд хариулт хэлнэ.

Б.Жавхлан: Хэдийгээр та зөвлөмж хэлж байгаа ч гэсэн иймэрхүү асуудлууд дээр дэмий хүлээлт үүсгэхгүйн үүднээс би хариулчихъя гэж бодож байна. Онцгой албан татвар гэдэг болбол энэ төсвийн орлогын одоо том энэ дүнд ороод л явна. Тэрнээс биш Онцгой албан татварыг одоо тамхины ч гэдэг юм уу, архины ч гэдэг

юм уу энийг буцаагаад салбарын ямар нэг төсөл хөтөлбөрийг санхүүжүүлэх зорилтоор гэж ашиглах хуулийн заалт боломж байхгүй. Тийм учраас таны ярьж байгаа зүйл хэрэгжих боломжгүй. Энийг харин эртхэн хэлье.

Д.Жаргалсайхан: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 71.5 дахь хэсэгт бусад Байнгын хороод Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны хуралдаанд гишүүн, нам, эвслийн бүлэг, төрийн аудитын төв байгууллага саналаа зарчмын зөрүүтэй саналын томъёоллын хамт гаргана гэж заасны дагуу санал гаргах гишүүн байна уу? За байхгүй байна.

Төсвийн тодотголын төслийн 2 дахь хэлэлцүүлгийг явуулсан талаарх Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооноос гаргах санал, дүгнэлтийг Монгол Улсын Их Хурлын гишүүн Ганбатын Очирбат Төсвийн байнгын хорооны хуралдаанд танилцуулна аа.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, ЭМД-ын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дахь хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

12:50

Д.Жаргалсайхан: Дараагийн хэлэлцэх асуудалд орёё.

Хэлэлцэх асуудал 3. Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны 2024 оны 2 дугаар тогтоолоор байгуулагдсан Тавантолгой түлш ХХК-ийн үйлдвэрлэл технологийн үйл ажиллагааны талаар шалган судлах, холбогдох санал дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий Хянан шалгах ажлын хэсгийн санал, дүгнэлтэд үндэслэн тус ажлын хэсгээс Засгийн газарт чиглэл өгөх тухай Байнгын хорооны тогтоолын төслийг боловсруулсан.

Дээрх тогтоолын төслийн талаарх танилцуулгатай холбоотой асуулт асуух гишүүн байна уу? Тогтоолын төслийг тараагаад өгсөн байгаа. Заавал унших уу? За асуулт.

П.Ганзориг: За гишүүдэд энэ өдрийн мэндийг хүргэе. Энэ ажлын хэсгийн гаргасан саналтай холбоотой Засгийн газарт чиглэл өгөх тухай энэ тогтоолын төсөлтэй холбоотой нэг 2 асуулт байна. Ерөнхийдөө зарчмын хувьд бол дэмжиж байгаа. Тэгэхдээ 1-д энэ тогтоолд агуулгын хувьд хоорондоо хамааралгүй гэх юм уу даа асуудлууд нэг дор орчихоор гишүүд тухайлбал заримыг нь одоо тухайлбал дэмжих гээд байдаг, зарим нь бас эргэлзээтэй зүйлүүд байгаад байдаг. Ингээд холилдоод орох нь зөв үү, үгүй юу?

Өөрөөр хэлбэл тогтоолын төслийн 1 дээр сайжруулсан шахмал түлшний стандартыг шинэчилж тогтоох асуудлыг дурдсан байгаад байгаа юм. Энэ бол чухал. Шинэчилж тогтоож гаргах ёстой. Тэгээд 2-т хувийн аж ахуйн нэгжүүд өөрсдөө бас стандартын дагуу зах зээл дээр чөлөөтэй өрсөлдөх боломжийг бүрдүүлэх ёстой энэтэй бас 100 хувь санал нэг байна. Тэгэнгүүт 2 дахь хэсгээс нь авхуулаад зөвхөн Тавантолгой түлш компанийн асуудал ороод ирж байгаа юм. Бүтэц, алдагдлыг яаж хаах вэ гээд энэ асуудлууд. Тэгэхээр энэ дээр ингээд холиод орчихоор нэгэн том

стандартыг шинэчлэх гэж байгаа шахмал түлшний асуудал. Нөгөөх нь нэг компанийн асуудал хоёрыг ингээд хольчихоор энэ тогтоолын төслийг батлахад бас асуудал үүсэх юм болов уу гэж бол хараад байна.

Тавантолгой түлш дээр тухайлбал энэ 2 дээр ЭТТ компаниас эргэн төлөгдөх нөхцөлтэй зээлээр санхүүжүүлсэн 1.5 их наяд төгрөг эргүүлэн төлж гэхчиг байгаа юм. Хаанаас хааш нь төл гээд байгаа юм гэдэг нь тодорхойгүй байгаад байна. Энийг нэг тодорхой зааж өгөхгүй бол болохгүй байгаад байна.

3-т энэ Тавантолгойн асуудлыг чинь бас бид нар нийслэл рүү шилжүүлнэ гээд тодорхой шийдвэрүүд гаргаад ингээд нэлээн процесс явчихсан шүү дээ тиймээ. Тэгэхээр эндээс нөгөө нийслэлийн өмч хөрөнгөтэй холбоотой зүйл дээр бид нар ийм шийдвэр гаргаад явахаар яах билээ гээд энэ зүйлүүдийг тодруулж асуугаад. Тэгээд хариултаас хамаарч байгаад тодруулж асууя. Баярлалаа.

Д.Жаргалсайхан: Асуултад ажлын хэсгийн гишүүн Очирбат гишүүн хариулна.

Г.Очирбат: За энэ асуудал бол зөв өө зөв. Бид нар чинь нөгөө тогтоол гаргаад нийслэл рүү явуулчихсан. Тэгэхдээ нийслэлийнх нь тэр мэдээлэл авахаар бид нар менежментийг нь л авсан гээд байгаа юм. Тэгээд яг хувьцаа нь бол Тавантолгой, ЭТТ дээр байгаа гээд байгаа байхгүй юу. Тэгэхээр ер нь бол ЭТТ-гоос Тавантолгой түлш чинь 1.5 их наяд төгрөг авчихсан. Яг одоогийн байдлаар. Тэгэхээр энэ Тавантолгой түлш компанитай холбоотой энэ асуудлаа ЭТТ 2 хоорондоо асуудлаа шийд ээ гэсэн л утга учиртай нэг.

Хоёр гэх юм бол ер нь цаашдаа энэ ЭТТ дээр гарч байгаа асуудлууд бусад тэр олон компаниудыг санхүүжүүлж байгаа асуудлыг ч гэсэн энэ дээрээ хариуцлагатай бай гэсэн утгаараа оруулж ирсэн.

Д.Жаргалсайхан: За ажлын хэсгийн гишүүн Очирбат гишүүн нэмэлтээр дахиад хариулт өгье.

Г.Очирбат: Тэгээд энэ асуудлыг энэ 2 компанийнх нь хооронд нь шийдэхгүй бол эргээгээд магадгүй энэ Улаанбаатар хот чинь юу ч хийж магадгүй байдалтай байна. Бонд гаргаад аягүй бол энэнийхээ өрийг төлчихье гэж магадгүй байна. Нэг бол татвар төлөгч нарынхаа татварын мөнгөөр төлчихье гэж магадгүй байна. Тэгэхээр энэ компаниудын хоорондын асуудлыг нь хооронд нь орхихгүй бол ямар ч шийдвэр гаргахад одоо эрсдэлтэй нөхцөл байдалд байгаа юмаа.

Д.Жаргалсайхан: Ганзориг гишүүн тодруулга асуулт.

П.Ганзориг: Яах вэ зарчмын хувьд бол дэмжиж байгаа бүгдийг нь. Тэгэхдээ би гол нь дараа нь энэ тогтоол маань хэрэгжихэд хүндрэлтэй байдал үүсэх вий гэдэг үүднээс санал хэлж байгаа юм. Тэгээд дэмжээд явуулахад бол татгалзах зүйлгүй ээ. Харин ийм санал оруулмаар байна. Тэр 2 дугаар зүйл дээр 1.5 их наяд төгрөгийг эргүүлэн төлөх гэж байгаа байхгүй юу. Хаанаас, яаж төлөхийг тодорхой заа. Тэгэхгүй бол хэн төлөх юм, хаанаас төлөх юм, ямар ч тодорхой юм алга. Тавантолгойгоо буцааж ЭТТ-доо төл гээд байгаа юм уу? За ийм асуудал байна.

2-т тэр юуг анхаараарай гэж би хэлэх гээд байгаа юм. Нөгөө нийслэл рүү өмч болгоод шилжүүлчихсэн асуудлыг эндээс бид нар шийдчихдэг. Нийслэл чинь тэгвэл нийслэлийн өмчийг чинь иргэдийн хурал чинь, Нийслэлийн иргэдийн хурал чинь тодорхой шийдвэрүүд хариуцаж гаргадаг шүү дээ. Тэгэхээр энийг бол яах вэ тогтоолын төслийг бол батлаад явахад татгалзах зүйл алга аа. Энэ 2 зүйлийг онцгой анхаараарай гэж хүсье. Баярлалаа.

Д.Жаргалсайхан: Ингээд гишүүд асуулт асууж дууслаа. Үг хэлэх гишүүд нэрээ өгье. Ингээд 2 гишүүн. Очирбат гишүүн, Золжаргал гишүүн үг хэлнэ. Очирбат гишүүн үгээ хэлье.

Г.Очирбат: Гэхдээ Ганзориг гишүүний гаргасан санал бас зөв өө. Энэ редакцын засвартайгаар бас аваад, тогтоолын төслөө дэмжээд явчихад бололцоотой байх аа гэж харж байна.

Д.Жаргалсайхан: За баярлалаа. Ингээд Золжаргал гишүүн үгээ хэлье.

Ж.Золжаргал: За редакцын засвартайгаар тэр саяын 2 дугаар функтээр 1 аравны наяд их төгрөгийг эргүүлэн төлөх эх үүсвэрийг шийдвэрлэх гээд өөрчилчихвөл Засгийн газарт чиглэл өгөх тухай тогтоол учраас тэр хүрээндээ шийдвэрлэгдээд явах байх аа. Тэгээд алдагдлыг барагдуулах арга хэмжээ авах гэдэг нь энэ чинь нөгөө Засгийн газарт чиглэл өгсөн тогтоол учраас Тавантолгой түлш компанид үүрэг болгохоор зохих юм болов уу. Тийм, тэрийг нь бас нэг хараад редакцын засвартайгаар хэлсэн нь дээр байх гэж бодож байна.

Д.Жаргалсайхан: За гишүүд үг хэлж дууслаа. Засгийн газарт чиглэл өгөх тухай Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя аа. Санал хураалт. Санал хураалтдаа бэлдье. За санал хураалт манайхан бэлтгэлээ хангасан бол санал хураалтад оролцъё, саналаа өгөөрэй.

Нийт гишүүдийн 76.9 хувийн саналаар тогтоолын төсөл батлагдлаа.

12:59

Д.Жаргалсайхан: За хэлэлцэх асуудал 4. Засгийн газарт чиглэл өгөх тухай Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье. Тус тогтоолын төслийг та бүхэнд тараасан байгаа. Ингээд тайлбар хэсгийг Улсын Их Хурлын гишүүн Жаргалсайханы Золжаргал гишүүн тогтоолын талаар танилцуулна аа.

Ж.Золжаргал: Дэлхий нийтээрээ уур амьсгалын өөрчлөлтөөс үүдээд Парисын хэлэлцээр СОР чуулга уулзалт гэх мэт олон улсын хэлэлцээрүүд байгуулагдаад, хүлэмжийн хийг ялгаруулахыг бууруулах тэр дундаа нүүрсний хэрэглээг багасгах шаардлага бий болж байгаа. Гэтэл Монгол Улсад эрчим хүч, аж үйлдвэр, эдийн засаг нь нүүрсэнд тулгуурласан хэвээр байгаа. Алсын хараа 2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт хүлэмжийг ихээр ялгаруулах хүнд аж үйлдвэрийн томоохон төслүүдийг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байгаа.

Тухайлбал Алсын хараа 2050-д Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 4.2.14-т зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр, нефть хими, кокс хими, металлургийн үйлдвэр, нүүрс угаах үйлдвэр, нүүрс, хими, нүүрс, эрчим хүч, метан хийн үйлдвэрлэл,

технологийн парк, ган, төмөрлөг, жонш баяжуулах үйлдвэр, алт цэвэршүүлэх үйлдвэрийг тус тус байгуулна гэж заасан.

Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан 14 мега төслийн 9 дүгээрт нүүрс хими, кокс химийн цогцолборыг ашиглалтад оруулна гэж 1.1.2.3-т хүрэн нүүрсний ордыг түшиглэсэн 300 мвт хүчин чадал бүхий ДЦС-ыг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд барьж байгуулна гэж. 1.3.6.3-т зүүн бүсийг говийн бүстэй интеграцлан хөгжүүлж, кокс, химийн бүтээгдэхүүн болон нүүрс, эрчим хүчний үйлдвэр, бусад дагалдах үйлдвэр бүхий үйлдвэрлэл технологийн паркийг төр, хувийн хэвшлийн түншлэлээр байгуулна гэж. За тэгээд түүнчлэн Дорноговь аймагт дотоодын түүхий эдийг түшиглэсэн газрын тос боловсруулах үйлдвэр ашиглалтад оруулна аа. Газрын ховор элемент боловсруулах үйлдвэрийн төслүүдийг бодлогоор дэмжинэ ээ.

Багануур, Налайх, Багахангай дүүрэгт хүнд үйлдвэрийн үйлдвэрлэл технологийн паркийг дагалдах бусад үйлдвэрийн хамт байгуулах хувийн хэвшлийг дэмжинэ. Нүүрс, химийн технологи эзэмших, нөгөө хүний нөөцийг бэлтгэх ирээдүйн томоохон төслийн техник эдийн засгийн үндэслэлийг тодорхойлох зорилгоор туршилт тохиргооны бага оврын үйлдвэр байгуулан хийн түлш, нийлэг материал, устөрөгч гарган авна аа гэж. Хүлэмжийн хийн тайлагналын тогтолцоог бэхжүүлж, нүүрстөрөгчийн кредит тооцох, арилжаанд оролцох нөхцөлийг бүрдүүлэн, ногоон санхүүжилт хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн салбар дундын зохицуулалтаар хангах эрх зүйн орчныг сайжруулна аа гэж тус тус заасан байна.

Нөгөө талаас Монгол Улс уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах чиглэлд дэлхий нийтийн өмнө үүрэг хүлээсэн тул аж үйлдвэржилтээ хөгжүүлэхийг нэн тэргүүнд тавихын зэрэгцээ хүлэмжийн хийн ялгаралт багатай байдлаар аж үйлдвэржилтээ төлөвлөх шаардлага бий болсон. Иймд үндэсний аж үйлдвэржилтээ хөгжүүлэхийн зэрэгцээ нүүрсхүчлийн хийн ялгарлыг багатай байдлаар төлөвлөх үүднээс мөн олон улсын байдал эрсдэлтэй дотоодын газрын тос боловсруулах үйлдвэрийн түүхий эд баталгаагүй байгаа тул нүүрсний нөөцөө шатахууны түүхий эд болгон ашиглах нөөц хувилбарыг мөн төлөвлөх шаардлагатай байна.

Иймд Алсын хараа 2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан зорилтуудыг хэрэгжүүлэхийн тулд Төрийн албаны тухай хуулийн 53 дугаар зүйлд заасны дагуу нүүрс химийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх стратеги төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэхийг Засгийн газарт чиглэл болгохоор Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны тогтоолын төслийг та бүхэнд танилцуулж байна аа.

Энэ стратеги төлөвлөгөөний хүрээнд шатахуун үйлдвэрлэж, импортын хамаарлыг бууруулах, кокс, нийлэг материал гэх мэт нүүрс химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд шаардлагатай татварын болон татварын бус дэмжлэгийг тодорхойлж, эрх зүйн орчныг сайжруулах санал, дүгнэлт боловсруулах. Мөн нүүрс химийн үйлдвэрлэлийг эрчим хүч, хаягдал усны ашиглалт, тэрбум мод, үндэсний хөдөлгөөнтэй уялдуулах, үйлдвэрээс ялгарах нүүрсхүчлийн хийг газрын тосны олборлолт ашиглах болон бусад шаардлагатай арга хэмжээг тодорхойлж, хэрэгжилтийг төлөвлөх шаардлагатай гэж үзэж байна. Хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү. Баярлалаа.

Д.Жаргалсайхан: Золжаргал гишүүнд баярлалаа. Дээрх тогтоолын төслийн талаарх танилцуулгатай холбоотой асуулт асуух гишүүн байна уу? За нэрээ өгье. Жангабыл гишүүн асуулт асууя.

Х.Жангабыл: Баярлалаа. Энэ тогтоолыг бол дэмжиж байна аа. Ер нь миний бодол болбол ирээдүйд нүүрс болбол ямар ч хэрэгцээгүй болно. Тэгээд болж өгвөл одоо гадагшаа экспортлох хэрэгтэй гээд бодож явсан. Бараг л сүүлийн 20-иод жил яригдсан даа. Нүүрс хэрэггүй болно гээд. Тэгсэн одоо нүүрснээс энэ газрын тосны бүтээгдэхүүн үйлдвэрлэж болохоор байна, бас газ ч одоо үйлдвэрлэж болохоор ийм чиглэл өгөх тогтоолын төсөл орж ирсэн болохоор дэмжиж байна аа.

Надад нэг асуулт байна аа. Энэ 1.2 дээр тэрбум мод үндэсний хөдөлгөөнтэй уялдуулах гээд заачихсан байна. Одоо тэрбум мод энд ямар хамаатай юм бол. Тайлбар өгөөч тийм.

Д.Жаргалсайхан: Хариултыг Золжаргал гишүүн.

Ж.Золжаргал: Энэ тогтоолын төсөл дээр салбар хоорондын уялдааг хангах нь энэ стратеги төлөвлөгөөний бас нэг хэсэг байх юм аа гэж. Тэгээд тэр дундаа тэрбум мод үндэсний хөдөлгөөнийг жишээ болгож татаж оруулсан байгаа. Тэр нь ямар учиртай гэхээр нүүрсний одоо энэ төлөвлөгөөнүүдэд орсон тэр нүүрсний том үйлдвэрүүд бол уурхайгаа түшиглэж байгуулагдана. Нүүрсний уурхайтай газар шүүрлийн ус байдаг. Тэгээд уурхайн дэргэд нуур үүсгэдэг. Ялангуяа манай тал хээр говийн бүсэд ийм усны их нэг дор цугларсан эх үүсвэр бол нүүрсний уурхайгаа л дагаж бий болж байгаа юм.

Тэгэхээр зэрэг тэрбум модын хүрээнд говийн тал хээрийн бүсэд мод тарих боломж бол ерөөсөө л нүүрсний уурхайнуудын дэргэд байгаа. Энэ утгаараа энийг бас одоо хөгжүүлснээрээ нөгөө олон улсад бид нар чинь нүүрсээ хэрэглэхээс өөр аргагүй. Тэгэхдээ бид нар бас мод тарьж байна аа гэдэг энэ уялдааг жишээ болгож ирж татаж оруулсан.

Д.Жаргалсайхан: Улсын Их Хурлын гишүүн Золжаргал гишүүнд баярлалаа. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Үг хэлэх гишүүд нэрээ өгнө үү, ингээд Замира гишүүн үг хэлнэ ээ.

С.Замира: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Уг нь энэ тогтоолын төсөл нь зөв юу цагт нь орж ирсэн байна. Бид нар өчнөөн жил одоо нүүрсийг ямар ч үнэгүйдүүлээд үнэ хүргэхгүйгээр ингэж зах зээлд гаргаад байдаг. Энийг одоо ажил хэрэг болгоод нефт гаргаж аваад л тэгээд газ гаргаж, дотооддоо эргэлдүүлэх нь ер нь ашигтай. Тийм учраас энэ тогтоолыг дэмжиж байна.

Д.Жаргалсайхан: Танд баярлалаа. Ингээд Ганзориг гишүүн үг хэлнэ.

П.Ганзориг: Энэ тогтоолын төслийг дэмжиж байгаа. Тэгэхдээ би нэг найруулгатай холбоотой нэг 2, 3 бас санал хэлчихье гэж бодож байна. Засгийн газарт чиглэл өгч байгаа болбол яг энэ нүүрс химийн үйлдвэрийг хөгжүүлэх стратеги төлөвлөгөө боловсруулах гэххээд байгаа юм. Тэгээд боловсруулсан бол батлуулах ёстой. Боловсруулж батлуулах байдаг юм уу, энэ Засгийн газраар батлуулах байдаг юм уу энийгээ тодорхой тавихгүй бол 4 дээрээ стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх, түүний хэрэгжилтэд хяналт тавих гэххээд байгаа юм. Тэгэхээр нөгөө батлагдаагүй

юманд хэрэгжилтэд хяналт тавина гэж юм байхгүй. Тэгэхээр энэ батлах асуудлаа тодорхой заавал зүгээр юм болов уу гэж бодож байна.

2-т дээрх стратеги төлөвлөгөөний хүрээнд шатахуун үйлдвэрлэж импортын хамааралтыг бууруулах кокс нийлэг материал гэх мэт гэхчээ байгаа юм. Тэгэхээр нөгөө олон юм ингээд орох юм шиг хоосон үлдээгээд, дараалан тогтоолын төсөлтэй холбоотой бас дотор нь ингээд өөр өөр юмнууд орох асуудлууд гарах вий дээ. Би бол зүгээр зэрэг гээд дуусгачхаж болоогүй юм уу гэх мэт гэдэг чинь ер нь энэ ялангуяа энэ чухал баримт бичгүүд дээр бол болохгүй үг шүү дээ. Хоосон аягүй том орон зайнууд үлдээж байгаа юм.

4 дээр бас хууль тогтоомжийг боловсронгуй болгох арга хэмжээ тодорхойлон уул ажлыг гэхчхэн байгаа байхгүй юу. Уул ажил гэдэг нь яг юуг хэлж байгаа юм. Уг ажлыг гэж байгаа юм уу. Энэ нэг найруулгын юм байгаад байх шиг байна. Энэ хэдийг найруулга дээрээ засаад, редакцын засвар хийгээд батлахгүй болбол жоохон агуулга найруулгын хувьд ойлгомжгүй байдал үүсэх ийм нөхцөл байдалтай байна шүү гэж хэлж байна. Баярлалаа.

Д.Жаргалсайхан: Гишүүд үг хэлж дууслаа. Засгийн газарт чиглэл өгөх тухай Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулна. Манайхан бэлтгэл санал хураалтад бэлдье. Санал хураалт явуулъя.

Санал хураалтын дүнг танилцуулъя. 10 гишүүн дэмжиж, 3 гишүүн татгалзаж, 76.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Пүрэвдаваа гишүүн маань бас дэмжсэн нь одоо техникийн саатлаас болж гацсан учраас дэмжсэнд тооцъё.

За ингээд бас тогтоолын төсөлтэй бол редакц хийлгэх саналууд ирсэн байгаа. Энийг одоо бас оруулж явна аа.

Ингээд Засгийн газарт чиглэл өгөх тухай Байнгын хорооны тогтоолын төсөл хэлэлцэж дууслаа.

Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдааныг хаасныг мэдэгдье ээ.

Улсын Их Хурлын гишүүдэд баярлалаа.

13:10

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ГЭРЭЭТ АЖИЛТАН

Д.ЭНЭБИШ